



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ
ҮНЭТ ЗҮЙЛ

Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэн “Эх хэл, эх түүх, өв соёл”-ыг нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл ондоошлын гүн ухамсартай, оюун санааны дархлаатай үндэстэн улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлийг цогцлооно.



АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Баянгэрэлийн БАТБААТАР

Зөвлөх:

Сэндэнжавын ДУЛАМ
Батсүхийн МӨНХБАДРАЛ

Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Бат-Амгалангийн БОЛДБААТАР
Өлзийбүрэнгийн ЖАМЪЯН
Ганбаатарын ОТГОНЖАРГАЛ

Туслан гүйцэтгэсэн:

Дэлгэрийн МӨНХ-ОД
Хашмаргадын ЭРДЭНЭГАРЬД

Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

Гэрэл зураг:

МРА.МН
Жамбалын БАТБААТАР /Баку/
Хишигтогтохын ТҮШИГ

Хавтасны зураг:

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



ГАРЧИГ

ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛИЙН УЧИР	8
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ	14
Төрт ёс, төрт ёсны үнэ цэн	18
Үндэстнээ нэгтгэх төрийн бэлгэдэл	20
Шинжлэх ухаанаар нотлогдох бахархал	24
Дэлхийд данстай соёлын өв	30
Дэлхийд бүртгэгдсэн биет бус өв	34
НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ	36
МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ	44
ЭРДЭМ СУДЛАЛ, НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ	52
ДЭЛХИЙН МОНГОЛ	58

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙН ӨЛГИЙ НУТАГ

Хүн төрөлхтний үүсэл хөгжил, оршихуйн мөн чанар, олон мянган жилийн турш хувьсан өөрчлөгдөж ирсэн. Хүний нийгмийн амьдралын үнэн мөнийг таньж мэдэхийн төлөөх эрэл хайгуул өдгөө дэлхийн улс орон бүрийн эрхэм тэргүүний зорилго болж байна. Зорин судлах, танин ухаарахын эрэл хайгуулд тухайн улс үндэстний оршихуйн нэгдмэл үнэт зүйлийг тодотгон ойлгож, түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн үлдээх уламжлал алс хэтийн зорилготой давхар бичигддэг нь жам ёсны эрх ашиг юм.

Монголчууд бид ч энэхүү дэг жаягийн дагуу улс үндэстний үнэт зүйлсээ дахин тодруулахдаа дэлхийн анхны төрт улсын нэг Хүннү их гүрнийг байгуулж, XIII зуунд Чингис хааны дэлхийн дайд тэлсэн Их Монгол Улсынхаа сүр хүчинд бишрэн залбирч, хүндэтгэн дээдэлж, төрт ёс, түүх шастираа эрхэмлэх үүрэгтэй улс үндэстэн, ард түмэн. Их түүхийн уртад өвөг дээдсийн байгуулж бүтээсэн төрт улс, монгол хүний мөн чанар, оршихуйн зүрхэн тольтод бадамлан ахуй үнэт зүйл, тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсон хил, хэл, нүүдлийн соёл иргэншил бол Монгол Улсын, монгол хүн бүрийн ерөөл ивээл юм.

Иймд монгол хүн дэлхийд бусдаас ялгарах онцлог, давуу талыг "бүтээлч сэтгэлгээ, оюуны чадвар өндөр, дасан зохицох чадвартай, эрчист монгол" хэмээн тодорхойлж, энэхүү үзлийг хүн бүрд бага наснаас нь төлөвшүүлнэ. Үндэсний нэгдмэл үнэт зүйлсээ сэргээн, үндэсний ижилсэл, ондоошлоо олж, эх түүхээ таниулан өвлүүлнэ. Онгон дагшин газар нутгаа эрхэмлэн дээдэлж, монгол хэл бичгийн соёлоо хүндэтгэн эх хэлний боловсролыг өндөрт өргөх, тал хээр, уужим говь, уул сарьдаг дунд эгшиглэн түгсэн язгуур урлагаа түгээн дэлгэрүүлэх замаар монгол оршихуйг дэлхийд таниулан, нүүдлийн соёл иргэншлийн өлгий нутгийн эзэд Монгол үндэстэн мөнхөд орших учиртай.

2050

Ундэсний нэгдмэл үнэт зүйл

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛИЙН УЧИР

“Нүүдлийн болон суурин хоёр иргэншлийг зүй зохистой хослуулсан нөхцөл байдлыг бүрдүүлэх төрийн үзэл баримтлал бий болгож, урт удаан хугацаанд цогцолбор байдлаар хэрэгжүүлэх бодлогод бидний нийтлэг үнэт зүйл суурилах ёстой юм. Өөрөөр хэлбэл хоймсон соёл иргэншлийн бодлогыг монгол хүн бүрийн дотор ухаанд бойжуулж, буйлуулах хэрэгтэй.”

Хөдөлмөрийн баатар, соён гэгээрүүлэгч Л.Түдэв

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, нэрт сэтгүүлч, соён гэгээрүүлэгч, оюуны их хүмүүн Л.Түдэв агсан нэгэнтээ үндэсний үнэт зүйл болон ялгарал, хөгжил дэвшил, алс хэтийн зам, нүүдлийн болон суурин соёл иргэншлийн хамтын хөгжлийн тухай өгүүлж байлаа. Түүнээс хойш арав гаруй жилийн дараа УИХ-аас Засгийн газарт Монгол Улсын ирээдүйн хөгжил 30 жилийн дараа буюу 2050 онд хаана хүрсэн байх вэ гэдгийг зурах, төлөвлөх, бүтээн байгуулалтыг удирдах, судалгаа шинжилгээг идэвхжүүлж, төрийн дархлааг чадавхжуулах үүрэг даалгавар өгч, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан. Уг бодлогын баримт бичигт “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийг тодорхойлж, ирээдүйн хөгжлийг дэмжих замаар Монгол Улсын оршихуйг хамгаалах, хүндэтгэх, өнө мөнхөд уламжлуулан үлдээхийн арга ухааныг батлан хуульчилсан нь хамгийн чухал ололтын нэг юм. Манай улсын хувьд нүүдлийн соёл иргэншлийн өв уламжлалыг үеийн үед тээж ирсэн аугаа их түүхийн өлгий нутаг төдийгүй суурин соёл иргэншлийг нүүдлийн соёл иргэншилтэй хослуулсан өвөрмөц аж байдлын хос тулгуур багана болгон хамтад нь хоршуулан хөгжүүлж, төлөвшүүлж буй. Өнөөдөр хүн амын гуравны нэг орчим нь мал аж ахуй эрхлэн, уламжлалт нүүдлийн соёлоо тээж амьдарч байгаа ч дэлхий дахинд нүүдлийн соёл иргэншил, нүүдэлчний амьдралын өлгий нутаг хэмээн үнэлэгдэж, хүндлэгдэж байгаа нь онгон дагшин

Бидний өнөөгийн соёл иргэншлийн хосолмол байдал даяаршин буй дэлхий ертөнцөд монголыг таних үнэт зүйл болно.



газар нутаг, нүүдэлчин зон олны ахуй амьдралын уламжлалт зан заншил, соёл өвөөс улбаатай юм. Энэхүү номд түүвэрлэн өгүүлж, дэлгэрүүлэн таниулах “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийн бодлого нь Монголын газар нутагт өнө эртнээс ухаант хүн амьдарч эхэлснийг батлах олон мянган жилийн өмнөх түүхэн олдвороос эхлээд өнөөдрийг хүртэлх, цаашлаад ирээдүй рүү хөтлөх мянга мянган жилийн оршин тогтнохуйн мөн чанарыг угтан хамгаалж, өргөн хүндлэхэд оршино. Газар нутагтаа хэрхэн амьдарч, хэрхэн зохион байгуулж, амьдралын хэв маягаа хөтлөн, зан заншил болгож өв үлдээн, өдөр тутмын үйл хэргээ алс хэтийн бодлого, үлдээх соёл болгож байсныг танин мэдэх нь бид бүхний хувьд ирээдүйгээ төлөвлөх, угтах замаа тодорхойлох үндэс суурь болох учиртай.



Домог, сураг бичээс

Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн ан ав, амьжиргаа, сүсэг бишрэлийн тухай олон мэдээллийг Хойд Цэнхэрийн хадны зураг хэлж өгдөг билээ.



Эх сурвалж: Удирдлагын академи, 2017

Иймээс ч манай үндэстэн өөрсдийн Үндсэн хуульдаа "Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэж заасан билээ.

Цаг үе бүхэн өөр өөрийн үнэ цэнтэй. Гэхдээ цаг хугацаа гэдэг өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн гурван хэлхээнд оршиж дурсамж, түүх, мөрөөдлийг бүтээж байдаг. Монгол Улсын оршихуйн бахархлыг сэргээн таниулж, ухааран ойлгуулах их эрлийн дунд яваа бид монгол хүний үнэ цэнийг хэрхэн тодорхойлж, хэрхэн үнэлж дүгнэж, хэрхэн хүндэтгэн эрхэмлэдэг вэ гэдгээ тунгаан бодох цаг нэгэнт иржээ. Ийн учирлахын шалтгаан нь аливаа нэг зорилго, зорилт нь шинэ хуучны зөрчил, мэтгэлцээн болон үгүйсгэлийн эрчээр хөгжиж, үнэн мөн чанараа олох нь бий. Харин тэрхүү үгүйсгэлийн өөдөөс сэргүүлж тавих баталгаа бол хөгжил дэвшил буюу шинжлэх ухааны ололт амжилт юм. Иймд Засгийн газраас өв соёл, үнэт зүйлийг хамгаалж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэхийн тулд шинжлэх



ухаан, инновацын ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлж, үр дүнг нь амьдралд хэрэгжүүлэхийг чухалчилсан. Учир нь өв соёл, үнэт дурсгал байлаа гээд түүнийг хамгаалах, таниулан дэлгэрүүлэхийн тулд орчин цагийн ололт амжилтыг нэвтрүүлж, хэрэглэхгүйгээр үр дүнд хүрнэ гэж үгүй. Тэр дундаа шинжлэх ухаан болоод инновацын шинэ эрин та бидний оюун бодлын хүчийг нэмж, хэрэглээг төгөлдөржүүлж, хурдыг тэтгэж буй энэ үед технологийн дэвшлээр түүхэн соёлоо хамгаалан үлдээх боломжийг эрэлхийлэх нь цаг үеийн шаардлага юм.

“Монголчуудын үнэт зүйл”-ийг тодорхойлох судалгааны үр дүнгээс харвал, манай ард иргэд Монгол Улсын нийтлэг үнэт зүйл гэдэгт нийт 20 гаруй хүчин зүйлсийг тодорхойлон нэрлэсэн байна. Үүнд: Үндэсний тусгаар тогтнол, Монгол хүн, Ёс суртахуун, Эрдэм боловсрол, Уламжлалт амьдрах ухаан, Хүнийг дээдлэх, Зан заншил, Ахмад үеэ хүндлэх, Түүх өв, соёл, Тус дэм, санаа тавих чанар, Эрх чөлөө, Үр хүүхэд, Эх оронч сэтгэлгээ, Ажил хөдөлмөр, Гэр бүл, Нэр төр, Хүнлэг сайхан сэтгэл, Байгаль орчин, Нийгмийн оюун санааны нэгдмэл байдал, Монгол хэл, Эв нэгдэл, Ардчилал, Хүний билиг оюун зэрэг багтжээ.

Зураг 2. Үнэт зүйлийг өвлүүлэх арга замын талаарх нийтийн үнэлэмж



Судалгаанаас харахад үнэт зүйлсийг өвлүүлэн үлдээхэд гэр бүлийн хүмүүжил, сургалт гол нөлөөтэй гэсэн байна.

Хүснэгт 1. Үнэт зүйлсийн суурь шинж чанарын цаг хугацааны хэлхээ

Суурь шинж	Хэмжээс	Өнгөрсөн	Одоо (2020)	Ирээдүй (2050)
		Монголын Эзэнт гүрэн	Монгол Улс	Монгол Улс
Оюун санаа	Засаглал	Сэцэдийн зөвлөл - Их засаг хууль	Тогтворгүй засаглал - тодорхой бус хөгжлийн философи	Хуулийн засаглал - хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм
	Ногоон хөгжил	Мөнх хөх тэнгэр	Байгалийн баялагт шүтсэн	Ногоон амьдралын хэв маяг
	Нийгмийн хөгжил	Мөнх хөх тэнгэрийн дор хүн бүхэн тэгш	Дэлхийн хөгжлийн суурь үзүүлэлт хангалтгүй нийгэм	Дундаж орлоготой, боловсролтой, эрүүл, идэвхтэй бүтээлч иргэд
Хурд	Эдийн засаг	Дэлхийн баялгийг хуваарилагч	Уул уурхайгаас хамааралтай эдийн засаг	Олон тулгуурт эдийн засаг-өндөр хөгжилтэй улс
	Дэд бүтэц-бүсчилсэн хөгжил	Торгоны зам, морин өртөө	Таатай байршил - үр ашиггүй хуваарилалт	Технологийн дэвшилд тулгуурласан хөгжил
Мөн чанар	Монгол хүн	Монголын эзэнт гүрний иргэн	Хүний хөгжлийн үзүүлэлт доогуур	Ирээдүйдээ итгэл төгс - чинээлэг дундаж давхаргад хамаарах хүн
	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Үл давтагдах нүүдэлчин соёл, сэтгэлгээ	Үнэт зүйлээ гээсэн Монгол	Үндэсний ижилсэл - ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн
	Үндэсний аюулгүй байдал	Пакс Монголика - Алтан гэрэгэ	Хоёр том гүрний хооронд оршиж буй Монгол Улс	Өрсөлдөх чадвар бүхий Монгол Улс

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар, 2021

Үнэт зүйлсийн нэгдэл

Бидний дотоод мөн чанар, үнэт зүйлсийн төлөөх эрэл хайгуул нь Монголчууд бидний оюун санаа, хурд, мөн чанарын нэгдэл гэж үзэж болно.

Эрдэмтэн судлаачид Монгол Улсын үнэт зүйлийг бүрдүүлэх мөн чанарын бүрэлдэхүүнд эх оронч сэтгэлгээтэй, зан заншлаа хүндэлдэг, түүх, өв соёл, уламжлалаа дээдэлдэг нийтлэг хандлага монголчууд бидэнд хэрэгтэй болохыг онцлон тэмдэглэснийг дурдах хэрэгтэй. Засгийн газраас үйл ажиллагааны чиглэл болгон хэрэгжүүлэх “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт мөн энэ тухай “Улс үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, монголчуудын уламжлалт төрт ёсны үзэл, сургаалыг орчин үед нийцүүлэн хөгжүүлж, эх оронч, үндэсний эв нэгдлийг төлөвшүүлнэ” хэмээн зорилтоо тодорхойлсон билээ.

Энэ талаар судалгаа хийдэг эрдэмтэн судлаачид “Монгол Улс, монгол хүний үнэт зүйл” гэдэг сэдвээр дагнасан судалгаа хийж, тайлан дүгнэлтээ олон түмний хүртээл болгож, төр засагт танилцуулсан байдаг. Мөн сүүлийн жилүүдэд Монгол Улсын хэмжээнд улс орноо танин мэдэх замаар дэлхийн шинжлэх ухааны ололт амжилтад хувь нэмэр оруулж, хүн төрөлхтөн болоод байгаль дэлхийн мөн чанарын эрэлд хариулт эрэгчид болох археологи, палеонтологи, антропологи, түүх судлал, угсаатан зүй, соёл судлалын салбарын ололт амжилт нэмэгдсэн. Зөвхөн Монгол гэлтгүй дэлхийн улс орнууд ч өөрийн орны онцлог, үнэт зүйл, иргэн байх мөн чанарыг тодорхойлох замаар үнэт зүйлээ түгээн дэлгэрүүлж, бусад улс орноос ялгарах ялгарал, ондоошлын зарчимд тулгуурлан хөгжүүлэх болсон.



Зураг 3. Монголчуудын үнэт зүйлсийг эрэмбэлсэн байдал



Азийн хүчирхэг гүрнүүд болох Өмнөд Солонгос, Япон, Хятад болон Европ, Америк тивийн улс орнуудад иргэддээ хүүхэд ахуй наснаас нь эх оронч үзлийг төлөвшүүлэх, үүний тулд боловсролын салбартаа тусгай сургалтын хөтөлбөр, хүмүүжлийн арга хэмжээг хавсарган хөгжүүлж байна. Үндэстний үнэт зүйлээ эрхэмлэн дээдэлсэн улс орон хаана хүрч болдгийг харуулсан Сингапур улс үүний тод жишээ юм. Бид ч энэ мэт жишгээр явах учиртай билээ.

Эх сурвалж: Удирдлагын академи, 2017

Хүснэгт 2. Үнэт зүйлсийн суурь ойлголтын үзүүлэлт

ҮНЭТ ЗҮЙЛС						
Өгөөмөр	4.18	-0.06	-0.12	-0.64	-0.21	-1.07
Нийцтэй	4.33	-0.32	0.32	0.23	0.34	-0.89
Уламжлал	3.21	0.21	0.73	0.27	-0.02	-0.64
Аюулгүй байдал	4.29	-0.76	-0.17	-0.09	-0.13	-1.28
Амжилт	3.89	-0.45	-0.39	-0.59	-0.18	-1.14
Өөрөөрөө байх	4.19	-0.55	0.12	-0.56	-0.17	-0.97

Эх сурвалж: Удирдлагын академи, 2017

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ЗОРИЛТ 1.1 Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурласан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшиж, эв нэгдэл нягтрах үе

— Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе —

ᠤᠨᠳᠦᠰᠦᠨᠢᠢ ᠪᠠᠬᠠᠷᠬᠠᠯ
ᠡᠪ ᠨᠡᠭᠳᠡᠯ


Бахархал гэдэг үг нь бахархах үйлийн нэр үг бөгөөд ямар нэг юм, үзэгдлийн сайн давуу талыг хүндэтгэн бахдах сэтгэлийг хэлдэг бол, үндэсний бахархал нь аливаа нэгэн улс орон доторх нийт хүн ам даяараа хүндэтгэж бахадсан түгээмэл нэг үнэт зүйл юм.

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ХИЙГЭЭД ЭВ НЭГДЛИЙН ҮНЭ ЦЭН

Үндэсний бахархал гэдэг хэн хүний хувьд хаана төрж өссөн, аль улсын иргэн байхаас үл хамааран улс эх орноороо бахархах, үндэсний соёл иргэншил, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх түгээмэл нэгэн үнэт зүйлийг илэрхийлдэг маш өргөн хүрээтэй ойлголт билээ. Монголчууд бидний эн тэргүүнд бичигдэх үндэсний бахархлын тухай ойлголт бол Монгол Улсын олон мянган жилийн хөгжлийн үүх түүх, тэдгээрийн явцад үүсэн бий болсон соёл уламжлал, газар нутаг, байгалийн зүй тогтол, хүн ардын амьдралын хэв маяг, нүүдлийн соёл иргэншил, ардчилал эрх чөлөөний мэдрэмж, төрт ёсны уламжлал, утга зохиол ном судлалын оюуны их өвийг багтаасан “Би Монгол хүн” гэдэг ялгарал, омогшил юм. Монголчууд хэзээнээсээ үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэх, үнэлж хүндлэх, улмаар шинжлэх ухааны түвшинд танин мэдэж,



Зураг 4. Үндэсний бахархлын ойлголтын үзүүлэлт



ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх өөрийн гэсэн өв уламжлалтай, түүнийгээ цаг үетэйгээ уялдуулан авч явсан түүхтэй ард түмэн. Иймд МОНГОЛЫГ МОНГОЛООР нь үлдээх эрхэм зорилгыг төрийн урт хугацааны бодлогын баримт бичигт тэргүүн бүлэг болгон тодорхойлсон бөгөөд дээрх хүсэл эрмэлзлийн ач холбогдлын хэр хэмжээг баталгаажуулсан хэрэг юм.


Үндэсний бахархлын тухайд зөвхөн хүн ардын бүтээсэн түүх бус байгалийн ялгарал, зүй тогтол, ховор нандин амьтан ургамлыг өргөмжлөн хүндлэх нь дэлхийн улс орнуудын төрийн хүндлэлд тооцогддог жишээ олон. Тухайлбал, Япон улс гэхэд үлгэр, домогтоо ихээхэн хүндэтгэлтэйгээр дүрслэн өгүүлдэг гургуул шувуу 1947 онд үндэсний бахархалт шувуугаар өргөмжилсөн төдийгүй үндэсний мөнгөн тэмдэгт дээрээ дүрсэлсэн байдаг. Мөн америкчууд аль тэртээ 1782 онд ариун нандин бэлгэдлийн шувуу хэмээн үндэсний бахархалт шувуугаар бүргэд шувууг онцлон сонгож, паспорт болон мөнгөн тэмдэгт дээрээ дүрсэлсэн. Монгол Улсын хувьд 2012 онд шонхор шувууг үндэсний бахархалт шувуугаар өргөмжилсөн.

Үндэсний эв нэгдэл хэмээх ойлголтын тухайд Их Монгол Улсын тэртээгээс олон овог, аймаг үндэстнээр нэгэн дээвэр дор нэгдэж, төр их улсыг байгуулсан түүхтэй манай улсын хувьд нэгдмэл нэг үндэстэн, олон угсаатны өлгий нутаг гэдгээрээ онцлогтой. Олон угсаатан гэж нэрлэгдэх боловч нэгдмэл нэг улс үндэстэн гэдгээрээ бид бахархдаг. Өнөөгийн Монгол орон дэлхийн бусад улс орноос нэг үндэстэн улс гэдгээрээ ялгардаг давуу талтай. Халх, дөрвөд, баяд, буриад, дарьганга, урианхай, захчин, дархад, торгууд, өөлд, хотон, мянгад, барга, үзэмчин, харчин, цахар, хотгойд, элжигэн,


- Маш чухал
- Чухал
- Чухал биш

Эх сурвалж: Удирдлагын академи, 2017

Оршин тогтнолын үндэс
Монгол улс дэлхийд оршин тогтнохын үндэс нь хэл соёл, үндэсний эв нэгдэл, хил хязгаарын бүрэн бүтэн байдал юм.



цаатан, сартуул, тува, хорчин, халимаг, түмэд, хамниган, хошууд зэрэг маш олон угсаатны зүйд хуваагдах монголчуудын өвөрмөц соёл нь дор бүрнээ Монгол Улсын үнэт зүйл, үндэсний дархлааг тээж байдаг. Аж төрөх ёс, гар урлал, амьдралын хэв маяг, нутаг усны зохицол, зан заншлын ялгарал байдаг ч монгол гэдэг нэг оршихуйг эрхэмлэдэг нь гайхмаар. Тиймээс ч Их Монгол Улсаас улбаатай олон угсаатан ястны оршихуйн их өлгий болсон Монгол Улсын эрт эдүгээ болон өнөө цагийн хөгжил нь үндэсний эв нэгдлийн эрхэм дээд үлгэр жишээ. Нутаг нутгийн зан заншил, үндэстэн ястны эв уламжлал, тэдний онцлогийг харгалзсан эв



Зураг 5. Хүннү гүрэн

Өвөг ард түмэн

Монголчууд Төв Азийн өндөрлөг нутагт хүн анх үүссэн цагаас эдүгээ хүртэлх хугацаанд оршин тогтносон. Үүний нотолгоо болж шинжлэх ухаанаар батлагдсан баримт сэлт, ул мөр улс орны өнцөг булан бүрд шинээр нээгддэг.

нэгдлийн нарийн уялдаа холбоо нь хөгжлийг бүрдүүлэгч үндсэн нөхцөл болдог. Энэ нь олон ястан үндэстний өв соёлтой танилцаж, тэдний ахуй амьдрал, газар нутгийн онцлог, ондоошлыг танин мэдэхийг хүссэн гадаад, дотоодын жуулчдын нэгэн сэдэл болдог нь бас нэгэн бахархал. Нүүдлийн болон суурин соёл иргэншлийн хосолмол ахуй ч бидний бахархал. Түүнийг дагасан амьдралын хэв маяг, орчин цагийн техник технологийн дэвшилтэй хөл нийлүүлсэн аж байдал ч мөн бидний бахархал. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн хэлхээс, нийлмэл оршихуй бидний бахархал, эв нэгдлийн суурь билээ.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ТӨРТ ЁС, ТӨРТ ЁСНЫ ҮНЭ ЦЭН



Төрийг тунхаглав

МЭӨ 209 онд Модун Шаньюй Хүннү гүрний төрийг зарлан тунхагласан нь Монгол газар нутагт тулгар төрийн суурийг тавьжээ.

Төрт ёс гэдэг бол ард түмний уламжлал, өвлөгдөж ирсэн тусгаар тогтнолын үзэл юм. Товчдоо, төрт ёсны ухаан нь тусгаар тогтнолын баталгаа. Төр улсаа удирдан чиглүүлж, төрийн эрх барих арга ухааныг өвлүүлэн түгээж, олон зуун жилийн турш эх орноо сахин хамгаалж ирсэн өв соёлын нэгдмэл уламжлалыг төрт ёс хэмээн энгийнээр тодорхойлж болох юм. Төр, улс орон бүр ард түмэн, тусгаар тогтнолоо хамгаалах, засаг захиргаа байгуулан удирдах, төр барихуйн ухааныг тээж, түгээдэг төрийн түшмэд, зүтгэлтэнтэй байдаг. Энэ бүхнийг шингээсэн дэг жаяг, уламжлал хүндэтгэлийг илэрхийлэх төрийн их ёс, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, төрт ёсны тухай ойлголтод багтан чухлаар үнэлэгддэг. Энэхүү эрхэм дээд үзэл санаа ард түмний дунд үеэс үед уламжлагдан хадгалагдаж, баяжин бэхжиж ирдэг.

Хүннү гүрний үеэс Төв болон Дорнод Азийн, тэр дундаа Монгол төрийн анхны суурь тавигдсан гэж үздэг. Модун хаан анхны төр улсыг эмхлэн байгуулсан гэж түүх судлаачид нотолдог. Хүннү гүрний төрт ёс, Сүмбэ, Их Нирун... Их Монгол Улс, Бага хаадын үеэс өв уламжлан дамжиж ирсэн Монгол Улсын төрт ёсны үнэ цэнийг ирээдүй үед өвлүүлэн чандлан үлдээх нь өнөөдрийн төр засаг болон монгол хүн бүрийн оршин байхуйн мөн чанар болно. Энэхүү үүх түүхтэй төрт ёс, төрийн онол, бэлгэдэл зүй, төрийн бодлого, ном эрдмээр дамжин өнөө үед уламжлан ирсний дээр төрийн гадаад харилцааны бодлогыг алтан аргамж, төрийн бодлогыг монгол төрийн алтан жолоо, алтан хайрцгийн бодлого, төрийн албан хаагчдыг төрийн түшмэл, бодлого боловсруулагчдыг төрийн түшээ зэргээр өргөмжлөн нэрлэж, хүндэтгэлийн хэлийг өргөн дэлгэр хэрэглэдэг уламжлалтай.

Төрийн бэлгэдэл зүйг эрт цагаас нар, сарны бэлгэдэлтэй байсан гэж үздэг. Хүннүгийн үеийн түүхэн олдворуудаас нар, сарны дүрс бүхий хүндэтгэлийн төрлийн эд олдвор олноор олдсоны дээр сурвалж бичигт “Хүннү нар өглөө наранд, орой саранд мөргөдөг байсан” хэмээн бичиж үлдээжээ.



Тэмүүжинийг хаан ширээнд залж, Чингис хаанаар өргөмжилсөн 1206 оны төрийн их хүндэтгэлийг *Монголын нууц товчоо*-нд “Эсгий туургатан энх болж, бар жилд Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүүжинд Чингис хаан цол өргөмжлөв” гэсэн нь өдгөөг хүртэл үргэлжилж, төрийн их цагаан, хар сүлдний бэлгэдлийг тахин залах ёслол болон уламжлагдаж иржээ. Тахилгын их цагаан сүлд нь Монгол төрийн сүр хүч, тусгаар тогтнол, эв нэгдлийн бэлгэдэл. Харин догшин хар сүлд нь Чингис хааны эцэг Есүхэй баатраас эхлэн Мандухай Сэцэн хатан, Баянмөнх даян хааныг хүртэлх түүхийн хугацаанд цэргийн сүр хүчийг бэлгэдэж ирсэн бөгөөд мянган хар азарганы хөхлөөр хийдэг нь сүр хүчний бэлгэдлийг илэрхийлж буй ёслол хүндэтгэл, өв уламжлалын дээд юм. Ийнхүү төрийн зараал, төрийн гэрэгэ, төрийн зарлиг зэрэг бодлого шийдвэрийг түмэнд хүргэх хэлц нэршил өнөө цагт ч уламжлан ирсэн нь Монгол төрийн залгамж халаа, төрт ёсны уламжлал өнө мөнхөд оршихуйн бэлгэдэл хэмээн үзвэл зохилтой.

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын төрийн далбаа нь мөнх тэнгэрийн хөх өнгө түүний хоёр талд мандан бадрахын улаан өнгөтэй, ишийн талын улаан өнгийн дунд алтан соёмбо байрлана” гэж хуульчилж, төрийн далбаандаа залсан нь XVII зууны соён гэгээрүүлэгч, өндөр гэгээн Занабазарын бэлгэдэл зүйг багтаан зохиосон соёмбо үсгийн дэг жаягаас эшилсэнтэй холбоотой.

Зураг 6. Төрийн бодлогын уламжлал

Алтан хайрцагны бодлого

Монголын Их хаадын боловсруулж, үе дамжуулан хэрэгжүүлж ирсэн төрийг удирдан жолоодох арга ухаан, цэрэг дайны хэрэг, ард түмнээ удирдан жолоодохтой холбоотой төрийн бодлогын хамгийн эрхэм чухал, чанд нууцлагдсан бодлого.

1

Алтан жолооны бодлого

Улс орны дотоодын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалтыг удирдан хөтлөхөд чиглэсэн төрийн тусгаар тогтносон, бүрэн эрхт байдлыг хамгаалж бэхжүүлэх, шашны талаар явуулах, нийгэм эдийн засгийн ололтыг хамгаалах, гэр бүлийг бэхжүүлэх, удмын сангаа хамгаалах, нийгмийн дэг журам, халамжийн тогтолцоо, байгаль орчноо хамгаалах цогц бодлого.

2

Алтан аргамжийн бодлого

Төрийн бодлогын гадаад харилцаанд хамаарах хэсгийг төлөөлөн илэрхийлэх бодлого нь олон улсын найрсаг харилцааг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах, дэлхий нийтийн энх тайвныг хангахад чиглэгдэж байжээ.

3



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ҮНДЭСТНЭЭ НЭГТГЭХ ТӨРИЙН БЭЛГЭДЭЛ



Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэх дэг

Төрийн сүлдийг үйлдэх,
дүрслэхдээ түүний хэмжээнээс
үл хамааран Үндсэн хуульд
хавсаргасан эх загварт заасан тэг,
харьцааг чанд баримтална.

ТӨРИЙН СҮЛД

Ариун цагаан өнгийн бадам суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээг хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог, хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байдаг. Сүлдний хүрээний магнай хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

ТӨРИЙН СҮЛД БАЙРЛУУЛАХ

- Монгол Улсын Төрийн тамганд;
- Монгол Улсын хилийн багананд;
- УИХ болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын хайрцаг дээр;
- УИХ, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан, Төрийн ордны соёмбот танхим, Ерөнхийлөгчийн өргөө, Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн Цэцийн албан тасалгаанд;
- Иргэдийн төлөөлөгчдийн болон Иргэдийн нийтийн хурлын байранд;
- Бүх шатны шүүхийн хуралдаан болон иргэдийн төрөлт, гэрлэлтийг бүртгэх танхимд;
- Бүх шатны Засаг даргын албан тасалгаанд;
- Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол Улсын яам, Засгийн газрын агентлаг, Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн хурлын тэргүүлэгчид, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хаягт;
- Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Монгол Улсын



Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн хурал, бүх шатны Засаг дарга, шүүх, прокурор, монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хэвлэмэл хуудаст;

- Галт тэрэгний зүтгүүр, суудлын вагоны хажуу талд тус тус байрлуулна.

ТӨРИЙН ИХ ЦАГААН ТУГ

Үндсэн хуулиар Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл бөгөөд Монгол Улсын төрийн туг юм.

ТУГИЙГ ҮЙЛДЭХ ДЭГ БА ХҮНДЭТГЭЛ

Төрийн тугийг Монгол Улсын бүх аймгийн адуун сүргийн дотроос шилж сонгосон цагаан зүсний азарганы 80.0 см-ээс доошгүй урттай, дэл сүүлээр, ганц хувь үйлдэнэ. Их цагаан тугийн өндөр нь ишний хамт 362.0 см байна. Төрийн тугийн ойрын хэсэгт гангаар сийлсэн, жийжүүдсэн хээтэй, сэрээ хэлбэрийн гилбэр байна. Их цагаан тугийн гилбэрийн үзүүрт дээшээ дүрэлзэж байгаа галын дүрс байрлуулах бөгөөд гилбэр нь тойрсон цэцгийн дэлбээ хэлбэртэй суурь (цар)-тай байна. Уг суурь болон титмийн

Есөн хөлт Их цагаан тугийг цэнгүүлнэ

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заасны дагуу Төрийн тугийг Үндэсний их баяр наадмын өмнөх өдрүүдэд цэнгүүлж, баяр наадмын өдөр наадмын төв талбайд хүндэтгэн зална.



Төрийн далбааг үйлдэх

- Төрийн далбааг улаан, хөх өнгийн хээгүй, цулгуй эдээр үйлдэнэ.
- Төрийн далбааг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, өргөн уртын 1:2-ын харьцааг чанд баримтална.



туурга, гилбэрийн галын дүрсийг монгол дархны аргаар алтдаж, шармалдана. Төрийн туг нь шаргал хээтэй цагаан хоргойгоор хийсэн дөрвөн хэлт манжлага бүхий бүслүүртэй байна. Бүслүүр, хэлийн уулзвар бүр дээр зэс хөөмөл дугуй толь байрлуулна.

Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөөний хойморт Есөн хөлт их цагаан тугийг байрлуулна. Жил бүрийн цагаан сарын шинийн нэгэнд төр, засгийн удирдлагууд их цагаан тугт хүндэтгэл үзүүлэх ёслол үйлдэнэ. Төрийн ордны хүндэтгэлийн өргөөнд гадаад орны төр, засгийн тэргүүн нар болон дипломат зочид төлөөлөгчид Монгол Улсын төр засгийн тэргүүн нарт бараалхах ёслол, Монгол Улсад суух гадаад орнуудын элчин сайд нарын итгэмжлэх жуух бичгээ өргөн барих ёслол, Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандан айлтгал хийх, төрийн дээд шагнал, одон медаль, цол хэргэм, зэрэг дэв соёрхон хүртээх ёслол зэрэг хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулна.

Үндэсний их баяр наадмын өмнөх өдөр төрийн их цагаан тугийг Төрийн ордноос жанжин Д.Сүхбаатарын талбайд залж, есөн шарга морьт цэрэг төрийн ордныг нар зөв гороолон цэнгүүлж, баяр наадмын өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнгийн төвд хүндэтгэлтэй залдаг. Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэн залах журамд заасны дагуу Төрийн тугийг хүндэтгэн залах ажиллагааг төрийн хонжин, тэргүүн тугч, тугчид гүйцэтгэх бөгөөд төрийн ёслолын торгон цэрэг хамгаална. Төрийн есөн хөлт Цагаан тугийг цэнгүүлэх ёслолын үйл явцад найман шарга, хоёр цагаан адуу оролцуулдаг нь буурал түүхийн нэг хэсэгтэй салшгүй холбоотой. Энэ нь

Их Эзэн Чингис хааны хамгийн хайртай найман шарга адуу болон Чингисийн хоёр загал гэж алдаршиж, түүхийн нэгэн хэлхээс болсон домогт хүлгүүдийн бэлгэдэлтэй холбоотой бөгөөд өнөө хүртэл монгол түмнийхээ дунд уламжлал болон ирсний баталгаа юм.

ТӨРИЙН ДАЛБАА

Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав нэгийн хэмжээтэй дундах хэсэг

хуваасны нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишийн талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.



ТӨРИЙН ДУУЛАЛ

Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийн нэг болох Монгол Улсын төрийн дууллыг Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн дагуу олон нийтийн өмнө эгшиглүүлэхэд оролцогч бүх иргэд босож, дуулж хүндэтгэнэ. Төрийн дууллын үгийг Төрийн шагналт, Ардын уран зохиолч Цэндийн Дамдинсүрэн зохиож, аяыг хөгжмийн зохиолч, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Билэгийн Дамдинсүрэн, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Лувсанжавын Мөрдорж бүтээж, 1950 онд баталсан байна.

ТӨРИЙН ТАМГА

Төрийн тамга нь дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй, хоёр талдаа Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна.



Төрийн тамга

Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина. 1206 онд Чингис хааныг Их Хааны сууринд залах ёслолын үеэр төрийн тамгыг нийт даяарт зарлан, хааны ордны бичгийн багш Тататунга хариуцаж байсныг сурвалж бичгүүдэд нотлон бичжээ.

ТӨРИЙН ТАМГА ҮЙЛДЭХ

Төрийн тамгыг цул мөнгөөр, гар аргаар, ганц хувь үйлдэнэ.

- Төрийн тамга нь 10.0x10.0x2.0 см хэмжээтэй, арслангийн дүрс бүхий бариулын өндөр нь 8.0 см байна.
- Төрийн тамганы дөрвөн өнцөгт бат бэхийг бэлгэдсэн холбоо түмэн насан хээ байрлуулан, Монгол Улс гэсэн бичээсийг монгол үсгээр эвхэж бичсэн байна.
- Төрийн тамгыг дуурайлган үйлдэхийг хориглоно.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ШИНЖЛЭХ УХААНААР НОТЛОГДОХ БАХАРХАЛ

Улс орны түүхийн баримт нотолгоог судалдаг шинжлэх ухааны олон салбар хөгжсөөр байгаа бөгөөд эдгээрээс манай орны антропологи, археологи, палеонтологийн шинжлэх ухааны ололт нээлтүүд үндэсний бахархал төрүүлэхүйц төдийгүй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж байна. Улс үндэстэн түүхэн баримт нотолгоог өөрийн эрдэмтэн мэргэдийн идэвх зүтгэлээр шинжлэх ухааны сүүлийн үеийн техник технологи, эрдэм шинжилгээний ололтоор батлах замаар бусдаар хүлээн зөвшөөрүүлэх нь тусгаар тогтнолын нэг гол үзүүлэлт болдог.

АНТРОПОЛОГИ

Антропологи нь хүн төрөлхтний болон хүний зан байдал, зан заншил, нийгмийн өнгөрсөн болон одоог шинжлэх ухааны үүднээс танин мэдэж, судлах замаар хүний мөн чанарыг тодорхойлдог шинжлэх ухаан билээ. Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд нийгмийн, хэлний, биологийн, эдийн засгийн, улс төр зэрэг өргөн дэлгэр түвшинд судлах болсон. Урьд өмнө нь угсаатны зүй судлал гэдгээр монголчууд илүү сайн мэддэг байсан бол орчин үед зан заншил, үүх түүх, нутаг ус, шашин шүтлэг, эдийн засгийн чадавх, бизнесийн орчин, улс төрийн чиг баримжаа, хоол хүнс, уламжлалт үйлдвэрлэл зэрэг олон талаас нь шигшин судлах болсон. Энэ нь тухайн улс гүрэн, хот тосгон, ард түмний ирээдүйн амьдрал, улс орны хөгжил, эдийн засгийн боломж бололцоо зэргийг бодитоор үнэлж дүгнэхийн үндэс бөгөөд үүний үр дүнд ирээдүйн хөгжил, нийгмийн хөгжлийг үнэн зөв тооцоолох боломжтой болдог байна. Өнөөг хүртэл энэ л газар нутагтаа, нүүдлийн ахуйгаа хадгалсаар үлдсэн амьдралын зан заншил, нийгмийн өөрчлөлт, сэтгэлгээний онцлог зэрэг нь бидний хувьд тулгамдаж буй сорилтоо даван туулах давуу тал болохыг илүү тодруулах шаардлагатай. Монгол орны уур амьсгал, байгалийн эрс тэс нөхцөл байдал, нийгэм, шинжлэх ухааны дэвшил улс орны болон хүн амын хөгжлийн асуудалд хэрхэн нөлөөлөхийг тогтоохдоо уламжлал, нүүдлийн иргэншлийн өдөр тутмын ахуйтай уялдуулж авч үзэх нь зүйтэй юм.



Их түүхийн баримт болон олдворуудыг шинжлэх ухаанаар нотлох замаар үндэсний бахархлыг бэхжүүлдэг.





АРХЕОЛОГИ

Археологи нь хүмүүсийн эдэлж, хэрэглэж байсан эд өлгийн зүйлс болон тэдний үлдээсэн ул мөрийг тусгайлан боловсруулсан арга зүйн дагуу судлан илрүүлэхийн зэрэгцээ өнгөрсөн үеийнх нь төрх байдлыг сэргээн хадгалдаг шинжлэх ухаан билээ. Ардчилсан хувьсгал эхлэхтэй зэрэгцэн нэгэн үе уналтад орж, судалгаа шинжилгээний ажил зөвхөн эрдэмтэн, судлаачдын нуруун дээр бууж байсан бол "Уул уурхай, зам, барилга зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлаас өмнө зайлшгүй археологийн дурсгалын хайгуул хийлгэсэн байх ёстой" гэдэг хууль, эрх зүйн орчин бүрдсэн нь археологийн салбарын хөгжилд дорвитой өөрчлөлт авчирсан юм. Мөн археологийн салбарыг төрийн бодлогоор дэмжихийн зэрэгцээ Археологийн хүрээлэнгээс жилдээ 35-40 орчим судалгааны багийг орон нутагт ажиллуулдаг болсон. Одоогийн байдлаар тус хүрээлэнгийн бүртгэл, мэдээллийн санд 100.0 мянга гаруй олдворын бүртгэл, мэдээлэл хадгалагдаж байна.

Хятаны үед холбогдох Хэрлэн барс хотын цамхаг

Хожим энд Халхын Сэцэн хан аймгийн чуулган чуулдаг болсныг "Хэрлэн барс хотын чуулган" хэмээн нэрийдэж байв.



Өөрсдийн нээлт

Луут хотын туурийг олсон нь Монголын археологичид цаашид өөрсдийн хүчээр түүхэн нээлт хийхийн эхлэл боллоо. Энэхүү нээлтээр хотын төв хэсэг 550x550 метрийн хэмжээст газарт буюу тухайн үеийн Хүннүгийн орд балгадаас хамгийн том талбайд барьсан давхар хэрэмтэй ордон байсан нь тогтоогджээ.



ХҮННҮ ГҮРНИЙ НИЙСЛЭЛ ЛУУТ ХОТ

Улаанбаатар их сургуулийн Археологийн тэнхимийн багш, археологич, доктор, дэд профессор Т.Идэрхангай болон түүний удирдсан судалгааны баг 2010-2013 оны хооронд Тамирын голын хөндийгөөр тархсан Хүннүгийн үеийн оршуулгын дурсгалыг бүртгэж, Хануй, Хүнүй голын сав газраар археологийн судалгаа хийх үеэрээ Тамирын голын хөндийд судалгааны гол ажлаа төвлөрүүлсэн байна. Улмаар 2017 онд тухайн бүс нутгаас Хүннүгийн нийслэл Луут хотыг илрүүлсэн төдийгүй 2019 онд “Шаньюй” гэсэн бичигтэй нүүр ваарын хагархайг олж, Хүннүгийн хааны ордны дурсгал болохыг тогтоосон байдаг. 2020 оны долоодугаар сард Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших Харганын дөрвөлжин хэмээх газраас Монголын газар нутагт үүссэн анхны төр улс болох Хүннү их гүрний нийслэл Луут буюу Хятадын эртний сурвалж бичигт тэмдэглэгдэж үлдсэнээр Лунчен хотын туурийг нээн илрүүлсэн нь дэлхийн археологийн түүхнээ онцгой нээлт болжээ. Уг Луутын хот хэмээх нэршлийг манай анхны археологичдын нэг “хөдөөгийн” гэдгээрээ алдаршсан Х.Пэрлээ тэмдэглэж үлдээсэн байдаг. Тэрээр энэ тухайгаа “Хүннүгийн нийслэл Луут хот Хангайн нуруунд бий” гэдэг таамгаар баяжуулан хойч үедээ үлдээсэн нь уг археологийн судлаачдын гол нэршил, чиг баримжаа болж өгчээ. 2020 оныг хүртэл археологийн олдвор болон түүхэн гаргалгаараа Хүннү их гүрнийг нийслэл хоттой байсан тухай баримт олдоогүй байсан тул



Хааны ерөөл

"Тэнгэрийн хүү Шаньюй, Тэнгэр шиг өнө мөнх, мянга түм насал" гэсэн үг бичээстэй байсан бөгөөд хотын саравчит хашааг "Тэнгэрийн хүү Шаньюй тэнгэр шиг өнө мөнх, урт удаан насал" гэсэн үгээр битүү чимсэн байжээ. Олдвортой зэрэгцэн уг хотын туурь давхар хэрэм, дөрөвний нэг нь хүний гараар хийсэн усан сан, ус явсан суваг хоолой, гурвалжин хэлбэрийн вааран дээвэр, модон багана зэргийг малтлагын явцад илрүүлсэн. Энэ нь цаашид судалгааны ажлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагыг зүй ёсны болгож байна. Энэхүү бүс нутагт эртний нийслэлийн ул мөрийг түшиглэн Төв Азийн судалгааны төв, соёл, аялал жуулчлалын цогцолбор болгон хөгжүүлэх үүд нээгдэж байна.



Язгууртны булш

Монголын археологичдын сүүлийн жилүүдийн нэг амжилт бол Хүннү гүрний язгууртны булшнаас илэрсэн эдлэл хэрэглэгдэхүүн болно. Хосгүй үнэт олдворууд Хүннүчүүд нүүдлийн соёл иргэншлийн анхны төрт улс байгуулж байсны нотолгоо болж байна.

Монголын бахархал

Монголын говиос 80 гаруй үлэг гүрвэлийн үлдэгдэл олдсон бөгөөд нээн илрүүлсэн судлаачид, олдсон газар нутгийнх нь нэрээр нэрлэгдсэн нь цөөнгүй.

Тарбозавр батаар

Ази тивд 70 сая жилийн өмнө буюу Цэрдийн галавын сүүл үед амьдарч байсан махчин динозавр.




Нэмэгтмайа

Цэрдийн галавын сүүлч үеэр буюу одоогоос 70 сая орчим жилийн өмнө амьдарч байсан шувуу төст динозаврын төрөл.



Барсболдиа

Өдгөөгөөс 80 сая орчим жилийн өмнө амьдарч байсан нугасан хошуут, өвсөн идэшт динозаврын төрөл.



Гобивенатор

Монголын говиос үлдвэр нь олдсон шувуу төст махчин динозаврын төрөл.



Ринчениа

Цэрдийн галавын сүүлч үед амьдарч байсан динозаврын төрөл. Нэрт палеонтологич Р.Барсболд нээж, өөрийн эцэг билгүүн номч Бямбын Ринчений нэрээр нэрлэжээ.



Шувууиа

Цэрдийн галавын сүүлч үеэр буюу 75 сая орчим жилийн өмнө Монголын нутагт амьдарч байсан шувуу төст жижиг динозаврын төрөл.



Гобититан

Цэрдийн галавын эхэн үе буюу 129-125 сая жилийн өмнө амьдарч байсан өвсөн идэшт динозаврын төрөл.




Гобизавр

Цэрдийн галавын дээд үед буюу 121-99 сая жилийн өмнө амьдарч байсан анкилозавр хэмээх өвсөн идэшт хуягт динозаврын төрөл.



Нугасан хошуут

“Гобихадрос Монголиенсис” буюу “Монголын говийн нугасан хушуут”



Нэмэгтмайа

Цэрдийн галавын сүүлч үеэр буюу 72-68 сая жилийн өмнө Монголын нутагт амьдарч байсан шувуу төст, холимог идэшт үлэг гүрвэлийн төрөл.



ПАЛЕОНТОЛОГИ

Палеонтологи нь эртний амьтан, ургамлын үлдэгдэл олдвор дээр тулгуурлан дэлхийн үүсэл хөгжил, зүй тогтол, цаг уур, газарзүйн өөрчлөлтийг судалдаг биологи, геологи зэрэг шинжлэх ухааны цогц юм. Монгол Улс палеонтологи судлалаараа дэлхийд данстайг батлах үнэт олдвор, судалгааны ажлын үр дүн олон бий. Дэлхий дээр 400 гаруй үлэг гүрвэл амьдарч байсны 80 гаруй нь буюу нээгдсэн таван үлэг гүрвэлийн нэг төрөл нь Монголын говиос олдсон. Эдгээрээс “Чойродон барсболдиа” хэмээн нэрлэсэн ургамал идэшт үлэг гүрвэл нь 120 сая жилийн өмнөх олдвор гэдгээрээ дэлхийн палеонтологийн шинжлэх ухаанд үнэлж баршгүй хувь нэмрийг оруулсан байдаг. Уг олдвор нь 120-125 сая жилийн өмнө буюу түрүү цэрдийн галавын үед амьдарч байсны дээр 4-5 метр урт, урд хоёр хөл нь харьцангуй илүү хөгжсөн боловч ихэвчлэн хойд хоёр хөл дээрээ явдаг, нугасан хошуут үлэг гүрвэлүүдийн өвөг байж болох аж.



Алдагдсан, буцаж ирсэн олдвор

Монголоор овоглосон үлэг гүрвэлийн олдворыг найдвартай хадгалах, олон нийтийн хүртээл болгох ажил чухал юм.

МОНГОЛЫН ГОВИЙН НУГАСАН ХОШУУТ

Сүүлийн жилүүдийн амжилтаас дурдвал шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн судлаачид 2019 онд үлэг гүрвэлийн дөрвөн зүйл шинэ төрөл зүйл буюу маш ховор Титанозаврын бүлгийн звароподын мөрийн олдвор илрүүлсэн байна. Ер орчим сая жилийн өмнө хуримтлагдсан хурдаст давхаргын шинэ төрөл зүйл болохыг нь тогтоож, “Гобихадрос Монголиенсис” буюу “Монголын говийн нугасан хошуут” гэж нэрлэсэн байна. Нугасан хошуут, өвсөн идэшт үлэг гүрвэлийн хөгжлийн дэвшилтэт бүлэг Умард Америкт эрчимтэй хөгжиж өргөн тархсан байдаг бол анх удаа Төв Ази, өнөөгийн Монголын говиос буюу Өмнөговь аймгийн зүүн хэсгээс тэдний өвөг дээдэс үүсэж хөгжсөн гэдгийг энэ удаагийн судалгаа, олдвороор тогтоожээ.

410 САЯ ЖИЛИЙН ӨМНӨ АМЬДАРЧ БАЙСАН ЭРТНИЙ ЗАГАС

Увс аймгийн Түргэний тусгай хамгаалалтай газраас 410 орчим сая жилийн өмнө амьдарч байсан эртний загасны шинэ төрөл зүйлийг илрүүлэв. Уг эртний олдворыг Монголын шилдэг геологич нарын нэг Ч.Минжин агсны нэр болон олсон газрын нэрийг хамтатган “*Minjinia turgenensis*” хэмээн шинжлэх ухаанд нэршүүлжээ. Эрдэмтэд “Загас төдийгүй хүнд яс үүсэж эхэлж байхад махчин загас харин мөгөөрсөн араг ястай байсан гэдгийг хөдөлгөөнгүй баримтаар нотолж чадлаа” гэжээ.

Далайгүй Монголын содон олдвор

Энэхүү загас Монгол оронд өргөн уудам далай тэнгис байсныг нотлоод зогсохгүй дэлхийн гарал үүсэл, үүх түүхийг нээн илрүүлдэг эрдэмтэн судлаачдын анхааралд өртөж эхэлжээ.





ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ДЭЛХИЙД ДАНСТАЙ СОЁЛЫН ӨВ

Буган чулуун дурсгал

Монгол Улсын хэмжээнд 550 орчим буган чулуун дурсгал байдаг бөгөөд зураасан зураг, сийлбэр уран баримлын аргыг хослуулсан сүрлэг уран баримлын дурсгал юм.



Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад Монгол Улсаас нийт 12 газар бүртгэлтэй бөгөөд хамгийн сүүлд буюу 2021 оны есдүгээр сарын 15-нд Нигер улсын Абужа хотод болсон ЮНЕСКО-ийн "Хүн ба шим мандал" хөтөлбөрийн Олон улсын зохицуулах зөвлөлийн хурлаас Монгол Улс, ОХУ-ын нутаг дэвсгэрт орших Увс нуурын хотгорыг ЮНЕСКО-ийн Хил дамнасан шим мандлын нөөц газрын ангилалд бүртгэн баталгаажуулсан байна.



СОЁЛЫН АНГИЛЛААР:

1. Амарбаясгалант хийд, түүнийг хүрээлсэн тахилгат, соёлын дурсгалт газар
2. Хөдөө арал дахь археологийн дурсгал, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар
3. Балдан Бэрээвэн хийд, түүнтэй холбогдох тахилгат газар нутаг
4. Буган хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор
5. Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор
6. Монголын говь дахь хадны зургийн цогцолбор
7. Тахилгат Биндэр уул, түүнтэй холбогдох соёлын дурсгалт газар
8. Монголын тахилгат уулс

БАЙГАЛИЙН АНГИЛЛААР:

9. Монголын говь дахь Цэрдийн галавын үлэг гүрвэлийн өлгий нутаг
10. Монголын Их говийн цөл нутаг
11. Дорнод Монголын тал нутаг.

ХОСОЛМОЛ АНГИЛЛААР:

12. Монгол Алтайн өндөр уулс





**Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад
2020 оны байдлаар бүртгэгдсэн өв.
Үүнд:**




БАЙГАЛИЙН АНГИЛЛААР:

1. Увс нуурын ай сав газар (2003 он)
2. Дагуурын ландшафт (2017 он)
3. Увсын хотгор (2021 он)

СОЁЛЫН АНГИЛЛААР:

4. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)
5. Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (2011 он)
6. Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг (2015 он)

Зураг 7. Дэлхийд бүртгэлтэй соёлын өвийн байршил



Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, 2021

Соёлын өв

Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий өвийг "соёлын өв" гэдэг.



Түүхийн гэрч

Хар балгасын эртний түрэг, нангиад, Согод бичээст хөшөөний үлдэгдэл.

ДЭЛХИЙН ӨВД БҮРТГЭГДСЭН ОРХОНЫ ХӨНДИЙ

Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг 2004 онд Дэлхийн өвийн хорооны XXVIII ээлжит чуулганаар Дэлхийн өвийн жагсаалтад соёлын ангиллаар бүртгэсэн байдаг. Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өвөрхангай аймгийн Хархорин, Бат-Өлзий, Хужирт сумдын нутагт 121,967 га газрыг эзэлдэг байна.

Орхоны хөндийд хуучин чулуу, хүрэл, төмрийн үеийн Мойлтын амын болон Орхон долоогийн бууц зэрэг эртний хүмүүсийн оромж, суурин, дархны газрын ул мөр элбэг бий. Энэ дурсгалт газар нь Түрэгийн үеийн хаадын тахилга шүтээний алдарт бунхант дурсгал, бичигт хөшөөнүүд, Уйгурын эзэнт гүрний нийслэл Хар балгас хотын туурь, Чингис хааны үндэслэсэн Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот, Монгол дахь Бурхан шашны бэлгэ тэмдэг болсон Эрдэнэзуу, Төвхөн хийд болон бусад олон дурсгалтай. Төв Ази улмаар хүн төрөлхтний түүхийн тодорхой давтагдашгүй бодит гэрч болж байдаг. Орхоны хөндийн Соёлын дурсгалт газар нь Төв Азийн нүүдэлчид, түүний дотор монгол үндэстний бий болгосон нүүдлийн соёл иргэншил, түүнийг хөгжүүлж ирсэн гол төвүүд болон улс гүрнүүдийн үүсэл хөгжлийг археологи, түүх, соёлын асар баян дурсгалаар нотлон харуулж байгаа гайхамшигт түүхэн нутаг юм.



Жуулчдыг татсан өв

Орхоны хөндий соёлын өвийг хадгалагч төдийгүй өнөө цагт жуулчдын сонирхлыг татсан онгон байгаль гэдгээрээ алдартай.



Олон увдисыг шингээгч

Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь:

- Монголын эзэнт гүрний төв
- Түрэгийн үеийн дурсгалын өлгий нутаг
- Ном бясалгалын орон хийдийн өлгий
- Монголын буддын шашны шүтээн нутаг гэдгээрээ онцлог юм.

ОРХОН ГОЛЫН ХӨНДИЙН ДУРСГАЛУУД

- **Хархорум хотын туурь.** Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт оршдог бөгөөд Чингис хаан 1220 онд Монголын эзэнт гүрний нийслэл болгон байгуулж, түүний залгамжлагч Өгэдэй хаан 1935 онд барьж дуусгасан түүхтэй.
- **Руни бичээс бүхий чулуун хөшөө.** VIII зууны эхэн үед Хөх Түрэгийн Билгэ хаан, Куль-Тегин нарт зориулан босгосон Орхоны бичээс бүхий хөшөөнүүд. Эдгээрийг Оросын археологичид 1889-1893 оны малталтаараа нээсэн байна.
- **Орд балгасын туурь.** VIII зууны үеийн Уйгурын эзэнт улсын нийслэл хот нь ордон, сүм, дуган, дэлгүүр гэх мэт маш олон тооны сүрлэг байгууламжуудтай 50 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг хамран оршиж байжээ.
- **Эрдэнэзуу хийд.** Монгол оронд Төвөдийн Бурхны шашин дэлгэрсний бэлгэдэл, анхны буддын сүм. Уг сүмийн зарим хэсгийг коммунист дэглэмийн үед 1930-1940 оны орчимд устгасан байна.
- **Төвхөн хийд.** Даяанч ламын агуй болох Төвхөн нь өвөрмөц, хосгүй сүм юм. Далайн түвшнээс дээш 2,600 метр өргөгдсөн уулын дээр орших уг хийдийг коммунист дэглэмийн үед нураасан байна.
- **Өгэдэй хааны ордны туурь.** Өгэдэй хааны амьдарч асан XIII-XIV зууны үеийн Монгол хааны ордны туурь.



ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ДЭЛХИЙД БҮРТГЭГДСЭН БИЕТ БУС ӨВ


Хадгалагдсан өв

Эзэн Чингис хааны үеэс төрийн ёслол хүндэтгэлийг морин хуурын аялгуугаар эхлүүлдэг байсан соёл өнөө хүртэл хадгалагджээ.



2003 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг баталсан. Соёлын биет бус өв гэдгийг уг конвенцоор “Хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйл, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ” гэж тодорхойлсон. Манай улс 2005 оны зургаадугаар сарын 29-нд дээрх конвенцод нэгдэн орсон бөгөөд улмаар бид үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвөө тодорхойлж, хамт олон, бүлэг хүмүүс, тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан түүнийгээ байнга шинэчилдэг тогтолцоонд шилжсэн. Ингэснээр өөрсдийн өв соёлын урт удаан оршин тогтнох үндэс болсон нийгмийн үе хоорондын залгамж чанарын мэдрэмжийг өдөөж, соёлын төрөл зүйл нэмэгдэх, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг болдог ач холбогдолтой.

Зураг 8. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн үзүүлэлт (төрлөөр)



Эх сурвалж: Соёлын өвийн үндэсний төв, 2021



Зураг 9. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл (өмчийн хэлбэрээр)



Энэхүү конвенцын зорилгод "Олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ" хэмээн тодорхойлсон байдаг. 2020 оны байдлаар ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт болон Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад нийт 549 өвийг бүртгэсэн. 2008 оноос өнөөдрийн байдлаар манай улсаас Соёлын биет бус өвийн конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай төлөөллийн жагсаалтад 15 биет бус соёлын өвийг бүртгэжээ.

- Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)
- Монгол ардын уртын дуу (2008)
- Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг (2009)
- Монгол тууль (2009)
- Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009)
- Монголын уламжлалт Хөөмийн урлаг (2010)
- Шувуучлахуй буюу Бүргэдээр ан хийх зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) (2010)
- Монгол баяр наадам (2010)
- Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил битүү амьсгаа (2011)
- Монгол уран бичлэг (2013)
- Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013)
- Монгол шагайн харваа (2014)
- Ботго авхуулах зан үйл (2015)
- Уул овоо тахих Монгол зан үйл (2017)
- Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019)

Эх сурвалж: Соёлын өвийн үндэсний төв, 2021



Соёлын биет бус өв Шагайн харваа

Монголчууд эртнээс "Бөх барилдвал бяртай, морь унавал эрэмгий, шагай харвахдаа мэргэн болоорой" хэмээн хүндэтгэн ерөөж ирсэн сайхан уламжлалтай. XIII зууны үеэс эхтэй уг соёлыг маань "ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад 2014 онд оруулж, сэргээн хөгжүүлэхийг дэмжихээр болсон юм.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ

ЗОРИЛТ 1.2 Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээлч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Нүүдлийн өв соёлоо хадгалж,
ёс заншил, уламжлалаа
түгээн дэлгэрүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Монголчуудын үндэсний
ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл
иргэншлийг хадгалсан тэргүүлэх
улс болох үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд
тулгуурласан бүтээлч монгол хүн төвтэй
нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан
тэргүүлэх улс болох үе

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

Дэлхий дээр 20 орчим соёл иргэншил байдаг. Тэдгээр нь институц, өв уламжлалаа даган хуваагддаг. Хүн төрөлхтний түүхийн өөрчлөлт шинэчлэл, хөгжил дэвшлийн харилцан хамаарлаас шалтгаалан нүүдлийн соёл иргэншлийн түүхэн улбаа бүдгэрч буй хэмээгддэг. Гэсэн ч өнөөгийн монголчуудын хувьд нүүдлийн соёл иргэншлийн сонгодог мөн чанарыг орчин цагт уламжлан тээж ирсэн гэдгээрээ дэлхийн соёлд үнэтэй хувь нэмэр оруулж буй юм.

Дэлхийн улс орны түүх өөр өөрийн үнэ цэн, үндэстэн ястны мөн чанар, газар нутгийн зүй тогтол, ард олны амьдралын хэв маягаар хөгжин баяжиж, тэр хэрээр дотоод мөн чанарыг эрж хайсан мөнхийн эрэл хайгуул болоод түүнийгээ авч үлдэх мөнхийн тэмцэл, хамгаалал дунд бүтээгдэж бий болно. Төв Азийн нүүдэлчин Монгол Улсын хувьд нүүдлийн соёл иргэншлийн түүх олон мянган жилээр яригдана. Өнөө цагт уламжлалт соёл иргэншлийн гэрч болон үлдсэн цөөн хэдэн үндэстний нэг болжээ. XXI зууны хөгжлийн эринд нүүдлийн ахуйг амьдралын дадал зуршил, хэв маяг, үнэт зүйлийн цөм оршихуй болгон авч үлдэж чадсанаараа ялгарах бахдал нь монгол хүн бүрийн сэтгэл зүрхэндээ тээж явдаг үнэт бахархал билээ. Даяаршиж буй дэлхий



ертөнцийн чиг хандлага эргээд үндэстний ижилсэл, ондоошил, оршихуйн мөн чанараа таних замаар үндэстний үнэт зүйлдээ онцлог оршихуйгаа тодруулж буй энэ үед “Нүүдлийн соёл иргэншилт Монгол” гэдэг тодорхойлолт дэлхийн дайдад манай улсыг тамгалан үлдэх нэг тамга юм.

Нүүдлийн соёл иргэншил олон хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Эдгээрээс малчин ард түмний бэлчээр даган нүүдэллэх амьдралын хэмнэл цөм нь болно. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын хувьд бэлчээр маш чухал. Бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх нь зэрлэг амьтдад ч тустай гэж үздэг уламжлалтай. Тиймээс малын тоог хэт өсгөхгүй байх, бэлчээрийг хуваарьтай, зүй зохистой ашиглах, өнжөөж амраахын үнэ цэнийг мэддэг байсан. Уламжлалт нүүдэл нь хангай говийн ялгаа, газрын гарц, түүний эргэлт, нутаг бэлчээрийн хүрэлцээ, малын тоо толгой, ус унд, чийг тунадас, хужир давс зэрэгтэй уялддаг. Говь хангай дамнан нутаглаж ирсэн уламжлалт нүүдэл өнөөгийн засаг захиргааны нэгжийн хилээр зааглагдан цаг агаар, бэлчээрийн

Зуун дамжсан нүүдэл

Монгол нүүдэл нь хангай говийн ялгаа, цаг улирал, нутаг бэлчээрийн хүрэлцээ, малын тоо толгой, ус ундны байдал, хүн малын өвчин зовлон, хужир давсны шаардлага зэрэгтэй уялддаг бөгөөд хангай газарт жилдээ 10 орчим, говь нутагт 10-14 удаа нүүж, шинэ буурь сэлгэх уламжлал бий. 2021 оны эцсийн байдлаар 188.6 мянган малчин өрх байгаагийн 74.8 хувь буюу 141 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэрээ болгож байна.

Үндэсний нэгдмэл
ҮНЭТ ЗҮЙЛС

**НҮҮДЛИЙН
СОЁЛ
ИРГЭНШИЛТ
МОНГОЛ**



Монгол адуу бие жижиг,
толгой томтой, хамар
гүдгэр, өргөн духтай.
Толгой нь богино,
булчинлаг хүзүүгээр
дэмжигддэг. Нуруу, ууц нь
хазайлгүй, өргөн байна.
Унжсан ууцан дээр сүүл нь
өндөр тогтоогдсон. Цээж
нь өргөн онцлогтой.




даац, хөрсний элэгдэл, цөлжилт зэрэг олон асуудлыг үүсгэж байна. Нөгөө талаар дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлт илүү ихээр мэдрэгдэх болсон нь асуудлыг өргөн хүрээнд авч үзэхийг шаардаж байна.

Учир нь бэлчээрийн доройтлоос үүдэн жилээс жилд малын ашиг шимийг нэмэгдүүлдэг шимт ургамлын тоо, төрөл цөөрч байгааг эрдэмтэн судлаачид анхааруулж байна. Эдгээр асуудлыг анхаарч шийдвэрлэснээр нүүдлийн соёл иргэншлийн суурь бэхжих болно.

Нүүдэл бол монголчуудын мөн чанар гэдгийг, эргээд ирээдүй цагт оршин үлдэх ондоошлын чанар. Нэг ёсны Монгол Улс байх, Монгол хүн байх үнэт зүйл өөрөө нүүдлийн соёл иргэншил, нүүдэлчин ахуй, нүүдлийн сэтгэлгээнд хамтдаа дархлагдаж ирсэн. Орчин цагийн хэрэгцээ шаардлага, амьдралын хэв маягаас үл шалтгаалан монгол хүн бүр нүүдлийн соёл иргэншлийн өв тээгчид гэдгээ мартаж боломгүй.

Зураг 10. Төв Ази болон Монголд морь малыг гэршүүлсэн он дараалал






Монголчууд улсаараа нүүдэлчин ард түмэн. Энэ бол бидний дархлаа, мөн чанар. Уудам дэлгэр газар нутаг, салхи исгэрэх морьдын төвөргөөн, цай дэвэрч, сүү цацрах идээ ундаа, учран золгож ерөөл өргөх монгол ёс, ахсаа алд хүндэлж, дүүгээ дэлэм хүндлэх өв эртний сургууль, уул усаа дээдлэх эрхэм ёсон. Энэ бүхэн монгол нүүдлийг дагасан өв соёл, нүүдэлчин монголчуудын ирээдүйд өвлүүлэх мөн чанар.

Нүүдэлчин түмний соёл, сэтгэлгээний их өвөөс зөвхөн нүүдэлтэй холбоотой ёс, зан заншлын талаар олон жишээ дурдаж болно. Эрт дээр үеэс монголчууд цаг тооны ухаан, нүүдэл цээрлэх ёс, арга бэлгэдлийг нүүдэллэх ёсондоо чухалчлан ирсэн байдаг.

Ингэхдээ нүүх өдөр, буух газраа эртнээс товлон тогтож, цэлмэг өдрийг сонгон нүүдэллэдэг уламжлалтай. Нүүхийн өмнөх өдөр ойр орчмоо хичээнгүйлэн цэвэрлэж, гүүн зэл, шон гадсаа сугалж, нүхэнд нь өтөг бууц, сул шороо хийдэг. Мөн ачаа хөтлөх мориныхоо дэлийг засаж, гэрийн эзэн бүрэн хэрэглэлтэй эмээл тохож ачаагаа хөтөлдөг заншилтай.



Монголчууд эртнээс уламжилж ирсэн эрийн гурван наамдын нэг нь хурдан морины уралдаан бөгөөд "Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм"-д заасны дагуу тавьж уралдуулдаг.





Нүүдэл цайлах ёс

Нүүдлийн цайны ёс гэж ёслол хүндэтгэлийн нэгэн том уламжлал бий. Нүүдлийн замд тааралдах нүүдэлчдийг хүндэтгэн идээ ундаагаар угтан ёсолдог.


Нүүдэллэхдээ хүүхэд ачсан, эд хогшил ачсан, цагаан идээ ачсан тэмээ гэх мэт нарийн дэс дарааллаар хөдөлдөг бөгөөд гэргий нь цай сүүний дээжээ тэнгэр хангайдаа өргөж, нутаг усны ээлтэй сайхныг сайшаан магтаж, аян замын ерөөл ивээл гуйдаг ёстой.

Нүүдэллэж очсон газраа гэрээ буулгахдаа нар зөв эргүүлж буулгадаг. Гэр барихдаа мөн л нар зөв тойруулан ханаа дугуйлж, туургаа ороон хошлонгоо татна. Гэрийн үүд тоононы харааг ямагт уулын оройг чиглүүлж барина. Харин хөтөл, хотгор газар руу чиглүүлэхийг цээрлэдэг. Ачаалж байх үедээ гэрийн буурь дээгүүр ачаатай, ачаагүй мал гаргахгүй. Энэ нь “ачаа хазайна”, “Ачаа туйлна” хэмээн цээрлэдэгтэй холбоотой. Нүүдэлчдийг заавал шинэ цайгаар цайлах ёстой. Эртнээс нааш хуучин цай өгөхийг шинэ бууринд удаан суухгүйн ёр хэмээн цээрлэдэг. Шинэ бууринд гэрийн эзэн түрүүлэн ирж, ачаа хөсгийг тосоход бэлдэнэ. Унаж ирсэн мориныхоо эмээлийг буурины зүүн талыг хандуулан тавина. Буух газраа бамбай дэвсэж, хүмүүсээ цайлж, хангай дэлхийдээ идээ цагаа өргөнө. Хуучин буурин дээр буухыг цээрлэдэг.



Ийм нүүдлийн ахуйн зан заншил, уламжлалт соёлыг өвлүүлэх замаар нүүдлийн соёл иргэншлийг бататган бэхжүүлэх ёстой. Нүүдлийн соёл иргэншлийг дэмжих, түүнийгээ үндэсний хөгжлийн онцлог болгон өргөмжилж, улмаар нүүдлийн соёл иргэншлийн төв нутаг гэдгээрээ дэлхий дахинд танигдах нь олон давуу тал бий болгоно. Үүнийг эдийн засгийн хөшүүрэг, орлогын найдвартай эх үүсвэр, аялал жуулчлал болон үйлдвэрлэл, соёлын экспорт болгон хөгжүүлэх боломж бололцоо бидэнд байна. Исланд улс гэхэд Европын орнууд дундаа соёлын өвдөө хамгийн их хөрөнгө оруулалт хийдэг улс орны тоонд орсон бол Гренланд, Норвеги улс ч энэ жагсаалтыг тэргүүлж байна. Норвегийн Засгийн газар гэхэд жишээ нь 2005-2013 оны хооронд улсын төсвийнхөө нэг хувийг соёлын салбартаа зарцуулсан байдаг. Түүхэн өвийг хадгалах болон соёлын төслүүддээ жилд дунджаар 11.2 сая хүртэлх ам.долларыг зарцуулдаг. Дэлхийн улс орнууд соёлын салбартаа ихийг зарцуулдаг ч, буцаад орлогын эх үүсвэр болгож байна. Жилд дунджаар дэлхий даяар соёлоос нийтдээ 2,250 тэрбум ам.доллар олж байгаа нь дэлхийн ДНБ-ий гурван хувьтай тэнцэх хэмжээ болно. Бид ч өв соёлоо дээдлэн хөгжүүлж, хөрөнгө орлогын эх үүсвэр болгох боломжоо нээх учиртай.

Зураг 11. Соёлд зориулж төрөөс хамгийн их мөнгө зарцуулдаг улс орнууд.



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ УЛАМЖЛАЛ



Монголчуудын бараг бүх хэрэгцээг хангадаг үндсэн аж ахуй нь байгалиас бүрэн хараат учраас байгалийг амьдралын эх булаг гэж үзэн дээдэлж ирсэн. Гол усыг бохирдуулж, мод бургасыг хамаагүй огтолбол гол ус ширгэж, хөрс, өвс ургамал хатдаг, ан амьтныг олноор нь агнаж, тоо толгойн зохист харьцааг алдуулбал амьтны болон ургамлын аймгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарч, бэлчээр доройтдог зэргийг олон зуун жилийн нүүдэлчин амьдралын туршлагаараа мэдсэний үндсэн дээр өвөг дээдэс маань байгаль орчиндоо ээлтэй хандаж, хайрлан хамгаалсаар иржээ. Бэлчээрийг цаг улирлын байдал, хол ойр, газарзүйн бүс бүслүүр, ургамлын бүрэлдэхүүн, мал сүргийн тоо толгой, сүргийн бүтцийг харгалзан хувааж ашиглах, бэлчээрийг өнжөөж амраах, хурлуулах, шинээр нээх зэргээр ашиглахын сацуу гал түймрээс сэргийлэх зэргээр өдөр тутамдаа байгалиа хөндөхгүйг хичээдэг байв. Нөхөн сэргэх нөөц, тухайлбал цас, хөрсөн, байгалийн сул чулуугаар хашаа хороо барьж аргал хөрсөн, хатаж унасан гишүү мөчир түлшиндээ хэрэглэх зэрэг хэвшлийг мөрддөг байв.



Байгальд ойр амьдрал

Монголчууд эртнээс эх дэлхийдээ ойр байж, түүхийг хайрлан хамгаалах үйлийг өдөр тутмын амьдралынхаа хэв маяг, дадал болгожээ.

ДЭЛХИЙН НҮҮДЭЛЧДИЙН НААДАМ

“Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г бүс нутгийн онцлогт тохируулан байгуулах буюу Говийн бүсэд палеонтологийн задгай музей, Хангайн бүсэд археологийн хотууд, Хөвсгөл Тайгын бүсэд цаатны отог, дархад бөөгийн отог, Даян дээрхийн агуйн цогцолбор, Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчдийн өв соёлын онцлогтой “Нүүдэлчин” олон улсын түвшний кино үйлдвэрлэл төвийг тус тус байгуулж, тэдгээрийг дагасан аялал жуулчлалын хөтөлбөрүүд бий болгож хөгжүүлнэ. Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулж, дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Дэлхийн нүүдэлчдийн наадам, фестиваль, урлаг соёлын форум, хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулах нь Монгол туургатны хэл, соёл, уламжлалыг хадгалж хөгжүүлэхэд ач холбогдолтой.



Дэлхийн монгол туургатны соёл

Монгол туургатны нэгдмэл соёлыг дэмжин нийтлэг болон ялгаатай байдлыг харьцуулан судалж, наадам чуулган зохион байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ

ЗОРИЛТ 1.3 Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Үндэсний монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Мэдлэг шингэсэн монгол хэл бий болгох үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Монгол хэл, бичиг үндэсний нэгдмэл үнэт зүйлийн бүрдэл болж төлөвших үе



Монголчууд шиг олон бичиг үсэг хэрэглэсэн ард түмэн дэлхийд бараг үгүй юм. Өнөөгийн монгол хэл нь монгол үндэстний эх хэл бөгөөд Монгол Улсын албан ёсны хэл болно. Хэл, бичгийн соёл бол тухайн улс үндэстний тусгаар тогтнолын дархлаа, соёлын үнэт зүйл, үндэстний эв нэгдлийн үнэт зүйл билээ.

ӨСӨХӨӨС СУРСАН ҮНДЭСНИЙ ХЭЛ

Дэлхий дээр 10 сая гаруй монгол үндэстэн амьдарч буй боловч тэдний 5.7 сая орчим нь монгол хэлтэн гэж болно. Тэдний дунд Монгол Улсын 3.4 сая иргэд орно. Монгол хэл соёлыг өвлүүлэн үлдээх, монгол хэл, монгол бичгийн дархлааг бэхжүүлж, монгол хэл, монгол бичгээр өвлөгдсөн бичиг соёлын үнэт өвийг хүндэтгэн хамгаалах, ирээдүй хойчид уламжлан дамжуулах үүрэг Монгол улсын төрийн бодлого, иргэн бүрийн хувьд эрхэм байх ёстой. УИХ-аас 2015 онд Монгол хэлний тухай хуулийг анх удаа баталж, “Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн”, “Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн”, “Монгол Улсын иргэн бүр монгол хэл, бичиг үсгээ сурах, монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх,

Зураг 12. Монголоор ярьдаг угсаатнууд



хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах эрхтэй” гэж заасан. Энэ хуулийн үндсэн үзэл санааг бүрэн ойлгохын тулд Монгол хэл, түүний утга санааг илэрхийлэгч монгол бичгийн түүхийг танин мэдэх нь чухал. Хэл нь харилцааны хэрэглүүр болон тухайн орон зай, цаг хугацаандаа хөгждөг. Харин бичиг үсэг нь сэтгэлгээний түүхийг өөртөө шингээн, илүү боловсронгуй болж хөгжихөөс гадна нарийн дэг жаяг, дүрэм журам баримтлан түүнийгээ хөгжүүлэх, нийтийг хамарсан шинж чанартай байх шаардлагатай тулгардаг. Монгол хэл бусад хэлний нэгэн адил энэ газар нутагт бодол санаагаа солилцох харилцааны хэрэгсэл болон хөгжсөнийг нотлох түүхэн баримт их. Хэлний хөгжлийн үе шат болох авиа, богино үгээр ярилцаж эхлэх тэр үеэс хүн төрөлхтөн адгуус амьтнаас ялгарсан гэдэг.

Хүний нийгэм, түүхийн хөгжлийн урт удаан хугацааны явцад хэлийг тэмдэглэх, бичиг үсэг үүсжээ. Хүн төрөлхтөн бичиг үсэгтэй болсноос хойших хэдэн мянган жилийн дотор маш олон үсэг бичиг бүтээсэн байна. Эдгээрийг зурагт бичиг, утгат бичиг, авианы бичиг гэж ангилна.

Дэлхийгээр тархан байршсан Афганистан, ОХУ, БНХАУ зэрэг 10 гаруй орны монгол угсаатнууд өдгөө монгол хэлээр ярьж байна.

Үндэсний нэгдмэл
ҮНЭТ ЗҮЙЛС


МОНГОЛ ХЭЛ,
БИЧИГ

Энэ жишгийн дагуу бичиг үсэг хөгжсөөр Монголчууд XIII зууны эхэнд уйгуржин монгол бичгийг нийтийн хэрэглээ болгон түүнээс хойш хэрэглэж ирсэн. Гэвч он цаг түүхийн хугацаандаа өөрсдийн хэрэглээ соёлдоо тохируулан бичиг үсгээ шинэчлэх, халах, сайжруулах, сольж өөрчлөх явдал цөөнгүй тохиосон тул олон бичиг үсэг хэрэглэж байсан онцлогтой.

Түүнээс ч өмнө Монголчуудын эртний өвөг болох Хүннү, Сяньби, Муюн, Тоба, Жужан нар тусгай бичигтэй байсныг судлаачид баталж байна. Кидан нар X зууны үед их, бага хоёр бичигтэй байсны дурсгал эдүгээ ч олдсоор байгаа.

Чингис хаан Найманыг 1204 онд эзэлсний дараа монголын зарим аймагт хэрэглэж байсан үсгийг түүний зарлигаар эзэнт улс даяар хэрэглэж эхэлжээ. Монголчууд XIII зуунаас бүр эрт уйгуржин бичгийн хэлтэй байсан ба үүнийг нотлох гол баримт бол:

- Монгол бичгийн хэл XIII-XIV зууны монголын аман аялгуунаас ихээхэн ялгаатай байгаа явдал юм. XIII-XIV зууны монголын аман аялгууг бусад хэлэнд галиглан тэмдэглэсэн ном зохиолоос тухайн үеийн монгол үгсийн дуудлагыг олж мэддэг билээ. Хэл





гэдэг цөөн жилд амархан өөрчлөгддөг зүйл биш тул бичгийн хэл нь аман аялгуунаас ихээхэн зөрөөтэй байна гэдэг бол тэрхүү бичгийн хэл, бичиг үсэг олон жилийн өмнө үүссэн гэж үзэх бүрэн үндэстэй гэсэн үг юм.

- Монголчууд XIII зууны үед боловсорсон утга зохиолын хэлтэй, бичиг хэрэг хөглөх тогтсон уламжлалтай байсны нэг нотолгоо бол 1225 онд бичсэн Чингисийн чулууны бичиг юм. Уг бичээст мөр тэтгэж бичих ёс тун нарийн харагдаж байдаг.

Монголчуудын дунд “уйгуржин монгол бичиг”, “монгол бичиг”, “худам монгол үсэг” анх хэдийд, хаанаас авсан тухай сүүлийн үед судлаачдын олонх нь зөвшөөрч буйгаар, эрдэмтэн Ц.Шагдарсүрэнгийн судалсанчлан “Монголчууд XIII зуунд согод үсгийг уйгураас дам авч хэрэглэсэнгүй, харин VI-VII зууны үед Монгол, Уйгур хоёр одоогийн Тажикийн дээд өвөг Согод нараас нэгэн зэрэг бичиг үсэг авсан байж болох баримт гарч байна” хэмээсэн буй. Юутай ч монголчууд согод гаралтай бичгийг авч, өөрийн хэлэнд тохируулан боловсруулж хэрэглэсэн тул монгол бичиг мянган жилийн түүхтэй юм.

Үгийн үндэс

Аливаа хэл амьд гэж ярьдаг.
Өөрөөр хэлбэл үг бүр амьтай.
Үгийн амин сүнс үгийнхээ үндсэнд
оршдог тул эх хэлээ танин мэдэх
нь үгийн үндсийг судалж ойлгохоос
эхтэй. Монгол хэл нэг үндсээс олон
салаалж утга илэрхийлнэ.

“Юань улсын судар”-ын 124 дүгээр ботид байгаа Уйгур тцшмэл

Тлатунгатай холбогдсон домог юм. Тлэнд: “Чингис өрнөш дайлж, Чайман улс эвдрэхүйд Тлатунга тамгыг авч дайжаад баригдав. Чингис хаан ухавчлан асууруун: - Даяны иргэд нутаг цөл миний болсон бөгөөтөл чи бээр тамга өвөрлөн хааш эчмүй хэмээхэд тэрбээр: “Тцшмэлийн тушаал болой. Чхтэл сахиж үгийн эзэнд өгсү хэмээмүй. Ямар аймшиггүй өөрийг сэтгэх аж” хэмээжүхүй. Хаан зарлиг болж, “Шударга элбэрэлт хүн ажгуу” хэмээгээд тамгыг юунд хэрэглэхийг асууваас: Аму цалинг оруулах, гаргах, эрдэмтнийг өргөмжлөх, аливаа үйлд хэрэглэж итгэмж болгомүй хэмээсэнд хаан таалж шадар болгожүхүй. Тлцүнээс хойш засаг зарлага тэргүцүтэнд тамга хэрэглэн цүсгэж мөн тцүгээр захируулав. Хаан “Чи тус улсын бичгийг нэвтэрхий мэдмүй” гэхэд Тлатунга сурснаа өчсөн нь зарлигт нийлэлцсэн тул даруй хөвгүд, дүч нарт уйгур цсгээр улсын хэлийг тэмдэглэхийг сургагтун хэмээн захиб” гэсэн байдаг.


Үндэсний нэгдмэл
ҮНЭТ ЗҮЙЛС

**МОНГОЛ ХЭЛ,
БИЧИГ**

Үе үеийн олон мэргэд монгол бичгийг өөрчлөлгүй явж ирсний гол шалтгаан бол Төв Азийн өргөн уудам нутагт тархан суусан олон нутгийн аялгуутай монгол туургатныхаа алинд ч бэрхшээл төвөггүй ойлгогдох авиа зүйн нарийн увдистай холбоотой. Өөрөөр хэлбэл монгол бичгийн авиан зүйн тогтолцоонд монгол хэлний нутгийн олон аялгууны онцлогийг гайхам сайхан тусгаж чадсан. Ийм учраас XXI зуунд амьдарч буй бид аль тэртээ хэдэн зууны өмнөх өвөг дээдсийнхээ бодол түүхэнд монгол бичгээр дамжуулан нэвтэрч чаддаг. Монгол хэл бичиг хөгжлийнхөө олон жилийн явцад эрт цагийн үгийн бүтцээ алддаггүйгээрээ онцлогтой.

Энэ гайхалтай хэл, бичиг үсгээ хөгжүүлэн авч үлдэх гарц бол иргэн бүр чанартай эзэмшин, хэрэглэж хэвших явдал юм. Гэхдээ тухайн үндэсний хэл гэдэг зөвхөн нэг улс орны ард түмний хэрэглээ идэвхжиж, тэдний мөн чанар оршихуй дээр тогтдоггүй бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд дэлхийн бусад улс орны иргэдэд өөрсдийн хэлний хэрэглээг нэмэгдүүлэхийг чармайх болсон байна. Жишээ нь, Япон улс гэхэд 2017 оноос эхлэн олон улсын соёлын солилцоог дэмжиж, япон хэлний хэрэглээг сайжруулах, түгээх чиглэлд ихээхэн анхаарах болсон.

Зураг 13. Дэлхийн хамгийн олон хүн ярьдаг хэл ба Монгол хэл



Өнөөдөр дэлхийн 7.8 тэрбум хүн 7,000 гаруй хэлээр ярьдаг боловч тэдгээрийн 40 орчим хувь нь устах аюулд ороод байгаа буюу 1,000 хүрэхгүй яригчтай үлдсэн байна. Гэхдээ ердөө 23 хэлээр дэлхийн хүн амын талаас илүү хувь ярьдаг. Тавин саяас дээш хүн ярьдаг 13 хэл байдаг. Монголчууд цөөхүүлээ ч түүхэндээ бичиг соёлын аугаа өвийг үлдээсэн ард түмэн билээ.


Эх сурвалж: INDIANA UNIVERSITY, 2022; Berlitz, 2021



БНСУ гадаадад оршин суугаа солонгосчуудынхаа хэлний хэрэглээг идэвхжүүлэх, үр хүүхдийнх нь эх хэлний мэдлэгийг дэмжихийн тулд дэлхий дахинд 2,000 гаруй “Хангьль” сургуулийг байгуулсан байна. Энэ нь тус улсын эх хэл, соёлоо мартуулахгүй байх үндэсний бодлого бөгөөд энэ хүрээнд Солонгос хэлний тайлбар толь, ХХI зууны Сэжүн төлөвлөгөө, Хангьль үсгийг цахим орчинд нэвтрүүлэх зэрэг олон ажлыг хийж хэрэгжүүлж байна.

Манай улсын 180 мянга орчим иргэн өнөөдөр хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа. Тэдний 4,000 орчим хүүхэд монгол хэл соёлын сургалтад хамрагдаж байна. Иймд Засгийн газраас монгол хэлний хэрэглээг идэвхжүүлэх, хэлний бодлогоор дамжуулан үндэсний үнэт зүйлээ хамгаалах, утга зохиолын өв соёлоо сурталчлахын тулд зөвхөн эх орондоо төдийгүй гадаадад байгаа монголчууд, тэдний үр хүүхэд, монгол хэлийг сонирхон судлагч бүхнийг дэмжих учиртай. Хэлний өдөр тутмын хэрэглээгээр дамжуулан хэлний дархлаагаа хамгаалдаг улс орнуудыг Франц улс тэргүүлдэг. Франц хэл нь дэлхийн хамгийн өргөн тархсан 15 хэлний нэг бөгөөд хамгийн алдартай "хэл хамгаалагч" улс гэгддэг. Франц аж ахуйн нэгжийн хаягийг англи хэлээр бичсэн тохиолдолд текстээс нь дор хаяж хоёр дахин том хэмжээгээр франц хэлээр бичих ёстой байдаг. Дэлхийн улс, үндэстэн болгон тухайн хэлээр нь олон хүн ярьдаг эсэхээс үл хамаарч хэлний шалгалтын стандарттай байдаг. Гадаадын их, дээд сургуульд элсэхийн тулд тухайн орны хэлийг зайлшгүй судалж, суралцсан байх шаардлагатай төдийгүй IELTS, TOEFL, TOPIC, NAT TEST зэрэг шалгалт өгч, хэлний түвшнээ тогтоодог. Манайд суралцаж, ажиллах хүсэлтэй гадаад иргэдэд монгол хэлний мэдлэгийн түвшнээ тогтоолгох боломж олгох "Монгол хэлний түвшин тогтоох стандарт шалгалт"-тай болно. Ингэснээр гадаадын иргэд болон төрийн албан хаагчид монгол хэлний ямар хэмжээний мэдлэг эзэмшсэн байх шаардлагатайг олон улсын нийтлэг жишигт нийцсэн арга зүйгээр түвшин тогтоох юм. Өнөөдөр манай их дээд сургуульд монгол хэлний мэдлэгийг шалгах стандартгүйгээр гадаад оюутан элсүүлдэг. Үүнийг өөрчилж анхан, дунд, ахисан гэсэн гурван түвшнээр шалгалт авснаар монгол хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй гадаад оюутан элсэх боломж бүрдэнэ. Хэлээ хөгжүүлэх, хэлний дархлааг хамгаалах тухай бодлого нь дан ганц үндэсний хэлээ сурах, ярих бус, сурах хялбар арга зам нээх, бусад хэлний харгалзсан толь бичиг зохиох зэрэг төрөл бүрийн арга хэмжээнүүд багтдаг.

Гадаадад эх хэл суралцагсад



4,000

орчим хүүхэд хилийн чанадад монгол хэл, соёлоо сурах сургалтад хамрагддаг.

Эх сурвалж: Гадаад харилцааны яам, Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл, 2019

ЭХ ХЭЛНИЙ СОЁЛ

- 2020 онд төрийн ордонд залсан Хүйс толгойн хөшөөний бичээс нь монгол хэл бичгийн түүхийг 1400 жилийн өмнөх цаг үе рүү хүргэсэн байдаг. Олдворыг шинжлэн тогтоохоос өмнө монгол хэлний хамгийн эртний дурсгалыг Чингисийн чулууны бичиг гэж үздэг байсан. Харин нийтийн тооллын өмнөх 630-аад оны үед хамаарах уг бичээсний үүсэл хөгжлийг шинжлэн тогтоосноор монгол хэлний түүх бүрэн утгаараа шинэчлэгдэж, урагшилсан нь энэ. Анх Могод сумын иргэд 1967 онд үл мэдэгдэх бичээс бүхий гурван хөшөөг олсон нь 150 см-ийн өндөртэй, 40 см-ийн өргөнтэй чулуу байсан бөгөөд энгэр талд нь 11 мөр бүхий бичээс байжээ. Эрдэмтэд уг бичгийг брахым бичгээр бичигдсэнийг тогтоосон ба бичгийг тайлж унших, үүх түүхийг танин мэдэх чиглэлээр цаашид ч судалгааны ажлаа үргэлжлүүлэх аж.



Түүхээс түүх рүү

Бичиг үсгийн түүх нэг үеэс нөгөө үед дамжин уламжлагддаг бөгөөд өмнөх үеэ таньж мэдсэнээр дараа үе илүү шинэ дэвшилд хүрдэг жамтай.



ХИЛИЙН ЧАНАДАД Ч МОНГОЛ ХЭЛЭЭ СУРАХ БОЛОМЖ



Монгол хэлний хэрэглээг дэмжих замаар эх хэлний дархлааг хамгаалах бодлогын нэг хэсэг нь нутгийн хэл, соёл, аман аялгууг хадгалах, хамгаалах чиглэлд анхааран ажиллахын зэрэгцээ иргэн нэг бүрийн хэлний хэрэглээ, тухайн эх хэлийг сонирхон судлагч хүн бүрийг хөхиүлэн дэмжихэд оршино. Уг зорилгын хүрээнд цаашид гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд, ялангуяа хүүхэд багачуудад монгол хэл, бичиг сурах эх хэрэглэгдэхүүнийг бүтээж түгээх, монгол хэлээ олон улсад сурталчилж, монгол хэлээр ярилцагч гадаадын иргэдийг алдаршуулан талархах явдал юм. Үүний тулд монгол хэлийг орчин үеийн мэдээллийн технологийн давуу талыг ашиглан дэлхийн хэл болгоход төрийн бодлого чиглэгдэх юм. Дээрх зорилгод хүрэх эхний алхам бол эх хэлээ зөв, бүрэн таньж мэдэх, гадаадынханд зориулсан сурах бичиг боловсруулахаас эхлээд монгол хэлний шалгалтын олон улсын системийг нэвтрүүлэх зэргээр шат дараатай хэрэгжих цогц төлөвлөгөө юм.



Хэл сурдаг зуслан

Америкт суугаа монгол хүүхдүүдэд зориулсан хэлээ сайжруулдаг зуны зуслан уламжлалт арга хэмжээ болжээ.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ЭРДЭМ СУДЛАЛ, НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ

ЗОРИЛТ 1.4 Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж, нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030


Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Гүнзгийрүүлсэн судалгааны бүх үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлээр судалгааны бүх үр дүнгийн хэрэгжилт хэвшил болж, нийгмийн соён гэгээрэл өндөр түвшинд хүрэх үе




Нийгмийн өвөрмөц онцлог бүхий оюун санаа, урлаг, утга зохиол, амьдралын хэв маяг, хамтын амьжиргааны арга хэрэгсэл, үнэт зүйлийн систем, уламжлал болон итгэл үнэмшлийг хамарсан цогц бүрдэл институцыг соёл гэдэг. Соёл иргэншлийн өрсөлдөөн улам бүр нэмэгдэж буй өнөөгийн ертөнцөд монгол үндэстний нүүдлийн иргэншил, хэл, түүх, соёлын институцыг бэхжүүлэхэд шинжлэх ухаан, судалгаа шинжилгээ, ялангуяа монгол судлалыг тогтвортой хөгжүүлэх ёстой.

Үндэсний өв соёл, уламжлал, үнэт зүйл, эв нэгдэл, нүүдэлчний соёл иргэншил хэмээх Монгол онцлогтой улс үндэсний оршин байхуйн мөн чанарыг илэрхийлдэг хүчин зүйлсийг судлан шинжилж, дэлхий дахинаа таниулан хүргэх бодлого тогтвортой, уламжлалтай, баримт нотолгоотой хийгдэх ажил юм. Үүнийг үйл хэрэг болгох нэн тэргүүний ажил бол олон улсын монгол судлалыг хөгжүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ. Монгол судлалын бодлогыг тодорхойлох, монгол судлалын институцыг хөгжүүлэх, дэлхийн монгол судлалын төв, эрдэмтэн судлаачдын



Зураг 14. Гадаад орнууд дахь монгол судлалын зарим төвүүд



сургалт, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, гаднын их сургуульд монгол судлалын төв шинээр нээгдэж, үйл ажиллагааг нь сэргээх, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, гадаадын залуу судлаачдыг бэлтгэн салбарын залгамж холбоог бэхжүүлэх зэрэг ажлыг хийж ирсэн уламжлалыг хадгалан тогтвортой тууштай үйл хэрэг болгохыг зорьж байна. Ингэснээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, соёл, шинжлэх ухаан, гадаад харилцааны бодлогын уламжлал, шинэчлэлийн залгамж холбоо, даяаршил ба дангааршлын зохист харьцааг оновчтой тусгасан монгол судлалыг хөгжүүлэх бүтээлч үйл ажиллагаа хэрэгжинэ. Эдгээр үйл ажиллагаа Монгол судлалын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх суурь судалгааны бүтээл туурвих, дэлхийн монгол судлалын шилдэг бүтээлүүдийг эх хэлээр, дотоодын монгол судлалын бүтээлүүдээс гадаад хэлээр орчуулан гаргах зэрэг ажлыг хийхээс эхэлнэ. Гадаад, дотоодод хадгалагдаж байгаа Монголын түүх, соёлд холбогдох судалгааны ховор хэрэглэгдэхүүн, баримт сурвалжийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах нь монгол судлал өргөжин хөгжихөд онцгой ач холбогдолтой хүчин зүйл юм.

Эх сурвалж: Гадаад харилцааны яам, 2022

Эдүгээ дэлхийн хорь гаруй орны 50 гаруй их сургууль, эрдэм шинжилгээний төвүүдэд олон зуун эрдэмтэд монгол судлалын сургалт, судалгааны ажил явуулж байна.

Үндэсний нэгдмэл
ҮНЭТ ЗҮЙЛС

**ЭРДЭМ
СУДЛАЛ,
НИЙГМИЙН
СОЁН ГЭГЭЭРЭЛ**

Монголч эрдэмтдийн хамтын ажиллагааг нэгтгэн зохицуулах, мэдээллээр хангах, монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих, Монгол судлалын солилцооны хөтөлбөр боловсруулж, хамтарсан төсөл хэрэгжүүлэх юм. Монгол судлалын төвүүдийг дэмжих, гадаад дахь үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, шинэ төв байгуулахад дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай. Мөн олон улсын залуу монгол судлаачдын зуны сургалтыг тогтмол зохион байгуулах, тэднийг солилцоогоор суралцуулах, эрдэм шинжилгээний бага хурлыг тогтмол зохион байгуулах зэрэг замаар шинэ залуу судлаачдыг бэлтгэнэ. Үнэт зүйлийн судалгаа, монголын түүх, хэл соёл, зан заншил, нүүдлийн соёл иргэншлийн судалгааг хийхэд олон улсын монгол судлал ихээхэн үүрэг гүйцэтгэх боловч судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох, шинжлэх ухааны үндэслэл, шинжилгээ баримт нотолгоотой асуудалд хандан өдөр тутмын хэрэглээ болгоход соёл урлагийн байгууллагын дотоодын сүлжээ, аймаг, орон нутгийн номын сан зэрэг байгууллагын үүрэг их.

Зураг 15. Соёлын байгууллагын тоо


Соёлын төв,
Соёлын ордон

72%




Киноны
байгууллага

8%



Урлагийн
байгууллага

7%



Музей

8%



Номын сан

5%



**2021 оны байдлаар Төрийн,
орон нутгийн болон хувийн
өмчийн соёл, урлагийн
нийт 482 байгууллага үйл
ажиллагаа явуулж байна.**

Тэдгээрийн 26 номын сан, 347 соёлын төв ба ордон, 37 нь киноны байгууллага, 38 нь музей, 34 нь урлагийн байгууллага байна.

Эх сурвалж: Соёлын яам, 2022




Өдгөө Монгол Улсын хэмжээнд төрийн болон хувийн өмчийн соёл урлагийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн гуравны нэг нь буюу 364 нь соёлын төвийн дэргэдэх номын сан. Тэдгээрийн 3.3 хувь нь Улаанбаатар хотод үлдсэн нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа. Улсын хэмжээнд нийтийн номын санд 6.2 сая орчим ном хэвлэл хадгалагдаж, жилдээ давхардсан тоогоор 2.3 сая хүнд үйлчилсэн гэх тоон мэдээлэл бий. Харин улсын хэмжээнд 38 музей 244.9 мянган үзмэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь эрдэм судлал-нийгмийн соён гэгээрлийн гол үүргийг гүйцэтгэж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд ч соёлын салбарын хөрөнгө оруулалтад ихээхэн анхаарч зөвхөн БНСУ-ын Засгийн газар гэхэд өнгөрсөн нэг жилд 429.7 тэрбум төгрөгтэй тэнцэх төсвийг энэ салбартаа зориулжээ. Үүний үр дүнд тус улсын эдийн засагт соёлын салбар тэр дундаа кино урлаг, дуу хөгжим, контентын үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдэж, зөвхөн хүүхэлдэйн кино, загвар зохион бүтээгчдийг гадаад зах зээлд гаргах болон к-поп зориулалтын концертын танхимыг барих зэрэгт 32.3 тэрбум воны хөрөнгө оруулалт хийж, к-поп урсгалын буюу энэ чиглэлийн зориулалтаар концертын танхим барихад зарцуулсан байна. Манай улс ч ийм туршлагаас суралцаж, өөрийн үндэсний онцлогт тохирсон соёлын бодлого хэрэгжүүлнэ.

Тухайлбал, 2022 онд Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Улсын драмын эрдмийн театр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театрыг сэргээн засварлахын зэрэгцээ соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоог хүн амын 75 хувьд хүргэх, нийтийн номын сангийн байнгын уншигчдын тоог хүн амын 15 хувьд хүргэх, музей үзэгчдийн тоог нэмэгдүүлээд зогсохгүй нэг хүнд ногдох номын сангийн номын тоо, соёлын төвийн суудлын тоог нэмэхээр төлөвлөжээ.

Ийнхүү нийгмийн соён гэгээрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг соёлын байгууллагаа дэмжих нь эргээд Монгол Улсын өв соёлыг мөнхжүүлэх, хүндэтгэх үйл хэрэг төдийгүй, хилийн чанадад үндэсний өвөрмөц зан заншил, соёл ахуйгаа сурталчлах үүд хаалга өнгө зүстэй, үзүүлж харуулах ур бүтээл улам өргөжин арвижихын илэрхийлэл юм.

**ӨНӨӨДӨР МАНай
УЛСАД НИЙТДЭЭ**



91,466

СУУДАЛТАЙ

347



**СОЁЛЫН
ТӨВ, ОРДОН**

**ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БАЙНА.**

Эх сурвалж: Соёлын яам, 2022

ДЭЛХИЙД БҮРТГЭГДСЭН МОНГОЛ ӨВ СОЁЛ

Монголын төрт ёсны түүхтэй холбоотой эртний эзэнт гүрний үед холбогдох археологийн малтлага судалгааг эрчимжүүлж, түүхийн бодит баримт, шинжлэх ухааны нотолгоо болгон түүх бичлэгт нэвтрүүлж, улмаар өөрсдийн хэзээ ч үл балрам түүхийн хуудсыг сэргээн таниулж, дэлхийн соёлын өв санг арвижуулна.



Түүхээ цэгнэнэ

Монголын түүхийг эргэн харж тодруулан, дэлхийн олон оронд байгаа эх баримтад тулгуурлан шинээр иж бүрдэл болгон бүтээж, олны хүртээл болгох, тухайлсан цаг үеийн болон болсон үйл явдлын гэрч, нотолгоонд үндэслэн бичиж хэвлүүлнэ (1289 онд Аргун хааны Францын IV Филип хаанд бичсэн захидал).



НОМЫН САН, БҮТЭЭЛИЙН ХӨМРӨГ



Монгол хэл бичгийн уламжлал шинэчлэлийг дэмжиж, үндэсний утга зохиол, ном судар, баримтат өвүүдийг бүртгэн, цуглуулагчдыг алдаршуулж, урамшуулна. Ялангуяа дэлхийн номын сангууд болон угсаатны зүйн музей, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хүмүүст хадгалагдаж байгаа бичгийн дурсгал, түүхэн сурвалж бичгийн өвийг бүртгэж мэдээллийн сан бүрдүүлж, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна.



Түүхэн сурвалж бичгийн өв

Монголын түүхэнд холбогдох баримт бичгүүд АНУ-ын Конгрессын номын санд болон дэлхийн бусад улс орнуудын томоохон номын сангуудад хадгалагдаж байна.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ДЭЛХИЙН МОНГОЛ

ЗОРИЛТ 1.5 Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Гүнзгийрүүлсэн судалгааны бүх үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлээр судалгааны бүх үр дүнгийн хэрэгжилт хэвшил болж, нийгмийн соён гэгээрэл өндөр түвшинд хүрэх үе



Монгол хэл, соёл урлаг, зан заншлыг тээгч ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих, Монгол Улсыг Монгол судлалын төв болгох зорилгоор дэлхийн монгол судлаачдыг дэмжих, дэлхийн өвд бүртгүүлсэн монголын соёлын өвийг хамгаалах талаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зэрэг нь “Дэлхийн Монголчууд” арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болно.

Монголчуудыг дэлхий дахин хэрхэн таньж, бусдаас ялгаж мэддэг эсэх, бусдаас ямар шинж чанараараа ялгаран тодорч, ямар дүр төрх, сэтгэгдэл хүнд үлдээж байна вэ? Төв Азийн цээжинд хоёр их гүрний дунд орших их түүхийн алдар суугаар нэрээ гаргасан цөөн хүн амтай ард түмнийг өнөөгийн дэлхий ертөнц хэрхэн таньж мэдэж байна? Ардчилал, эрх чөлөө, зах зээлийн эдийн засаг, уул уурхайн баялаг зэрэг хүчин зүйлс биднийг үнэлэх үнэлэмжид хэр нөлөөтэй байж чаддаг бол зэрэг олон асуултын нэгдсэн хариу үндэсний танигдахуйн тодорхойлолтыг бүрдүүлдэг. Эрс тэс уур амьсгалд дөрвөн улирлаар нүүдлэн амьдрах ахуйн хэв маяг, бидний хөрвөх, дасан зохицох чадварыг хөгжүүлсэн гэж үздэг. Шинэ зүйл, гадаад хэл сурахдаа сайн. Сэтгэл зүйн баригдмал бус, арга эвийг олохдоо түүртэхгүй зэргээр ч үнэлсэн байдаг. Цаг



баримтлахдаа тааруу, тууштай бус, зөрчилдвөл нүүгээд явчихдаг гэж тэмдэглэсэн нь ч бий. Мэдээж түүх, өв соёл, үндэсний бахархал, эх оронч үзэл, ирээдүйн хөгжлийн мөрөөдөл, төсөөлөл ч энд чухал байр эзэлнэ. Үүнийг тухайн үндэстний дотоод мөн чанараас эрэлхийлдэг. Түүгээр дамжуулан үндэсний нэгдмэл байдлаа хангахыг ч эрмэлздэг жишиг бий. Дэлхий дээр еврейчүүд гэхээр хүн бүрд нэг ойлголт зурсхийдэг. Тэгвэл дэлхийд монгол хүний талаар нэгдмэл эерэг төсөөлөл, сэтгэгдэл төрүүлдэг байх үндэс, суурийг тавихыг зорьж байна. Биднийг дэлхий зөвхөн өнгөрсөн түүхийн бахдам үйл явдлаар бус орчин цагийн мэдлэг, мэргэшил, оюуны цараа, овсгоо самбаагаар таньж, хүндэлдэг болоход биднээс их зүйл шаардана.

Бидний эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс, өдөр тутмын амьдралдаа мөрдөх зарчим, дэлхий нийтэд үнэлэгдэх үндэстний онцлогоо бид хайрлан дээдлэх учиртай. Гадаадын жуулчдад танигдах бидний амьдрал, харийн нутагт биднийг төлөөлөн харилцах оюутан залуус, гадаадад жуулчлах монголчууд, хилийн чанадад оршин суугч иргэд төдийгүй монгол гэсэн нэгэн нэрээр дуудагдах туурга

Тусгаар Монгол

БНМАУ 1961 оны аравдугаар сарын 27-ны өдөр НҮБ-д элссэнээр дэлхий дахинд тусгаар тогтнолоо баталгаажуулсан.

нэгт монголчуудыг хамаарна. Монгол улсад жилд дунджаар 500-600 мянган жуулчин ирдэг бол, 80-100 мянган монголчууд гадаадад зорчиж байна.

Шинэ ардчилсан үндсэн хуулиар олгогдсон оршин суух газраа сонгох эрхийг өдгөө монголчууд бүрэн дүүрэн эдлэх болсны дээр 2015 онд 120 мянган иргэн хилийн чанадад оршин суугаа судалгаа гарсан нь манай улсын нийт хүн амын дөрвөн хувь, нийслэлийн хүн амын есөн хувь, хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэдийн 26 хувьтай тэнцэнэ. (2019 онд 197 мянган иргэн хилийн чанадад оршин суугаа дүн гарсан байдаг.)

Дэлхийд монголыг таниулах нэг арга бол соёлын элч томилох явдал юм. Гадаад харилцааны яамнаас дэлхийн 19 улсад монголыг сурталчлах манай улсын 51 соёлын элч төлөөлөгчийг сонгон

Зураг 16. Хилийн чанадад монголчууд хамгийн их суурьшсан улс, орнууд



НИЙТ ИРГЭД
163,437

Эх сурвалж Гадаад харилцааны яам, 2021

Монголын 163,437 иргэн (2021 оны арванхоёрдугаар сарын 31-ны байдлаар) хилийн чанадад амьдарч байгаагаас хамгийн олноор суурьшсан таван улсын тоонд БНСУ, АНУ, Япон, Чех, Швед улсууд багтаж байна.



шалгаруулж, хамтран ажиллаж байна. Монгол Улсын нэрийг дэлхийд гаргаж буй этно рок “Хү” хамтлаг, балетчин, Монгол Улсын гавьяат жүжигчин Д.Алтанхуяг, дуурийн дуучин, Чингис хаан одонт Г.Ариунбаатар, дуурийн дуучин, Монгол Улсын гавьяат жүжигчин Э.Амартүвшин, Элчин сайд асан, Австрали дахь Соёлын элч Жон Лантри тэргүүтнүүд зэрэг алдартнууд Монголын элч төлөөлөгчийн үүрэг хүлээсэн байдаг. Дэлхий дахинд монголчуудын 130 холбоо монголчуудын эрх ашгийг хамгаалах, тэдний ажиллаж хөдөлмөрлөх болон сурч мэдэх эрхийг хамгаалахын төлөө ажиллаж байна.

Мөн монгол хүүхдүүдэд эх хэл, эх түүх, соёл уламжлалаа өвлүүлэн үлдээхийн төлөө дэлхийн улс орнуудад монгол хэл, соёлын түвшин үйл ажиллагааг дэлгэрүүлж, төрийн бодлогоор дэмжих нь дэлхийн даяар тархан суух монголчуудыг бага балчраас нь бэлтгэх, монгол эх орноо хүндэтгэн дээдлэх их өв уламжлалыг үлдээх ач холбогдолтой.

Тусгаар тогтносон Монгол эх орон, газар нутаг, эртний түүхт энэ нутагтаа оршин суугч болон дэлхийд монгол хэмээн нэрээ дуурсгагч Монгол хүн, үндэстний дахин давтагдашгүй шинж чанарыг хадгалах нүүдлийн соёл иргэншил, түүнийг даган хөгжих түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, орчин цагтай хөл нийлүүлэн хөгжих уламжлал, шинэчлэлийн зохицол бүгдийн нийлбэрээр илэрхийлэгдэх монгол хүний эрхэмлэх үнэт зүйл, эв нэгдэл улс орны минь оршихуйн дархлааг бөхөлж баталгаажуулна.

Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол урлагаар дамжин төлөвших Үндэсний бахархалаа тодруулан олон нийтийн хүртээл болгох замаар эв нэгдлийг нягтаруулна. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан үзэл санаагаар нүүдлийн соёл иргэншлийн төв болох зорилт хангагдана. Монгол хэл, монгол бичгээ дээдлэн, хүн бүрийн хэрэглээний хэвшил болгож, дэлхийн монгол судлалыг дэмжин дэлгэрүүлж, дэлхийд монгол хүний үнэлэмжийг өсгөнө.

Ийм эх түүхтэй орны иргэд бид эрдэм оюуныг дээдэлж, эрэмгий тэмүүлэлтэйгээр ирж буй цагийг хамтдаа бүтээх болно.



Дэлхийн улс орнуудад өөрсдийн өв соёл, онцлог уламжлалаа түгээн таниулахад хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг монгол сургууль, сургалт судалгааны байгууллага, хэл, соёлын төвүүдийн оруулах хувь нэмэр асар их юм.



ДЭЛХИЙД ТАНИГДСАН МОНГОЛ



Монголын түүх, соёлыг олон улсад сурталчлан таниулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үндэсний онцлог, агуулга бүхий олон ангит кино, тайз дэлгэцийн бүтээлийг дэмжиж, бүтээлийн тоог нэмэгдүүлнэ. Олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож амжилт үзүүлсэн баг, уран бүтээлчдийг дэмжин урамшуулна.



Дэлхийд алдартай монгол

Монгол Улсын нэрийг дэлхий дахинаа цуурайтуулсан гавьяат, спортын алдартан, урлагийн зүтгэлтэн, уран бүтээлчдийг дэмжин тэднээр дамжуулан эх орноо сурталчлах, үндэсний брэнд бий болгох, жуулчдыг татахыг зорино.



МОНГОЛ СУРТАЛЧИЛГАА



Монголын уламжлалт спорт наадам, наадгайг хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын төв байгуулж, үндэсний багтай болох, гадаад дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг дэлгэрүүлэх нь Монголыг сурталчлах нэг гарц юм. Хүний сонирхлоор дамжуулж, соёл уламжлалаа түгээх энэ бодлогын нэг хэрэгжилт бол өнөөдөр хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын санаачилж байгаа наадам болно.



Дэлхийд таниулах монгол наадам

Хилийн чанад дахь монгол иргэдийг өв соёлоо хадгалж хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, монгол хэл, соёлын агуулга бүхий сурах бичиг, ном товхимол, цахим агуулга, бүтээлүүд бий болгон түгээж, харилцаа, хамтын ажиллагааг дэмжинэ.

ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. (1994). Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль. УБ.

Монгол Улсын Засгийн газар. (2021). "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга . УБ.

Гадаад харилцааны яам, Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл. (2019). Манай улсын 180 мянган иргэн хилийн чанадад оршин сууж байна. Өдрийн сонин: <https://dnn.mn>

Гадаад харилцааны яам. (2022). Гадаад орнууд дахь монгол судлалын төвүүд. <https://mfa.gov.mn/28039>

Гадаад харилцааны яам. (2022). Салбарын мэдээлэл. УБ.

Соёлын яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Соёлын өвийн үндэсний төв. (2021). Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт.

Ц.Дамдинсүрэн, Монголын нууц товчоо. УБ.

Удирдлагын академи. (2017). Монголчуудын үнэт зүйлсийг Шварцийн аргачлалаар тодорхойлсон нь. УБ.

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Малчин өрхийн тоо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://1212.mn/>

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс. (2021). Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад 2020 оны байдлаар бүртгэгдсэн өв. УБ.

INDIANA UNIVERSITY. (2022). Languages of the Central Asian Region. INDIANA UNIVERSITY BLOOMINGTON: <https://celcar.indiana.edu/materials/language-portal/mongolian/index.html>

Berlitz. (2021). The most spoken languages in the world. <https://www.berlitz.com/blog/most-spoken-languages-world>

Natural History Museum. (2022). Dinosaurs in Mongolia. <https://www.nhm.ac.uk/discover/dino-directory/country/mongolia/gallery.html>

Nation master олон улсын зах зээлийн судалгааны байгууллага. (2022). Total Government Spending on Culture and Leisure. <https://www.nationmaster.com/nmx/ranking/total-government-spending-on-culture-and-leisure>

ТОВЧИЛСОН ҮГСНИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгол Улс
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СУИС	Соёл Урлагийн Их Сургууль
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага